

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Өвөрхангай аймаг
2010-2019 он

Энэхүү эмхэтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.
Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

Арвайхээр хот, Өлзийтийн 1 дүгээр гудамж, 118 дугаар байр

Факс:

Утас: 99668055

Э-шуудан: Natsagnyam95@gmail.com

<http://www.ov.mohs.gov.mn/>

uvurkhangaiemg@gmail.com

Хянан тохиолдуулсан:

Я. Жаргал

Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн
хэлтсийн дарга

Эмхэтгэсэн:

Д. Нацагням

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн асуудал
хариуцсан мэргэжилтэн, Статистикч их эмч

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НОМ ЗҮЙ

ХУРААНГУЙ

БҮЛЭГ I. ХҮН АМ ЗҮЙ

БҮЛЭГ II. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БҮЛЭГ III. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

БҮЛЭГ IV. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

БҮЛЭГ V. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

БҮЛЭГ VI. ХАЛДВАРТ ӨВЧИН

БҮЛЭГ VII. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

**БҮЛЭГ VIII. ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ, НАС
БАРАЛТ**

БҮЛЭГ IX. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

БҮЛЭГ X. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

БҮЛЭГ XI. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

БҮЛЭГ I. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ

Энэ бүлэгт Өвөрхангай хймгийн хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, дундаж наслалт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав.

Мэдээллийн үндсэн эх үүсвэр нь Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс жил бүр эрхлэн гаргадаг Эрүүл мэндийн үзүүлэлт, Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газрын жилийн эцсийн эргэн мэдээлэл, сарын мэдээ, үйл ажиллагааны үндсэн болон бусад тоон тайлан, Өвөрхангай аймгийн Засаг даргын тамгын газрын статистикийн хэлтсийн тоон тайлан болно.

Хүн амд манай аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Өвөрхангай аймгийн харъяат хүн амыг хамруулна. Өрх гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөө амьдарч байгаа хүн амыг хамруулна. Төрөлтийн хүйсийн харьцаа нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

Төрөлтийн ерөнхий коэффициент нь 1 000 хүнд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо амьд төрсөн хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, промилиор илэрхийлнэ.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент нь тухайн насны бүлгийн 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд тухайн насны бүлэг дэх эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, промилиор илэрхийлнэ.


Төрөлтийн нийлбэр коэффициент нь нэг эмэгтэйн нөхөн үржихүйн нас /15-49/-ныхаа туршид төрүүлэх нийт хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд насны бүлэг дэх төрөлтийн коэффициентүүдийн нийлбэрийг насны бүлгийн интервалын уртаар үржүүлж, 1 000-д хувааж тодорхойлно.

ХҮН АМ


Өвөрхангай аймгийн хүн ам 2019 оны жилийн эцсийн байдлаар 115737 болж өмнөх оныхоос 908 буюу 0.8 хувиар буурсан байна. Арвайхээр суманд 32891 хүн буюу нийт хүн амын 28.4 хувь нь оршин сууж байна. Хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99.1 байна. Насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 31.3 хувийг, 15-64 насны хүн ам 64.2 хувийг, 65-аас дээш насны хүн ам 4.5 хувийг тус тус эзэлж байна.

Өрхийн тоо 2019 оны байдлаар 9235 болж, нийт өрхийн 33,0 хувь нь 1-2 ам бүлтэй, 37,9 хувь нь 3,4 ам бүлтэй, 25,1 хувь нь 5,6 ам бүлтэй, 4,0 хувь нь 7 дээш ам бүлтэй амьдарч байгаа бөгөөд ихэр хүүхэдтэй 331 өрх бүртгэгдсэн бөгөөд нийт өрхийн 1,0 хувийг эзэлж байна. Ихэр хүүхэдтэй нийт өрхийн 99,4 хувь нь 2 ихэр хүүхэдтэй, 0,6 хувь нь 3 ихэр хүүхэдтэй байна.

Зураг 1. 1.Өвөрхангай аймгийн хүн амын тоо



Зураг1. 2. 2019 оны дундаж хүн амын тоо, сумаар



Эх үүсвэр: Өвөрхангай аймгийн ЗД-ын дэргэдэх статистикийн хэлтэс

Зураг 1. 3. Хүн, амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь




Эх үүсвэр: Аймгийн статистикийн хэлтсийн хүн амын тооллогын тоонд тулгуурлан үзүүлэлтийг тооцоолон гаргаж.

Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь нь өгөөдсөн хугацаан дахь хүн амын тооны бодит өсөлт, бууралтыг хувиар харуулах бөгөөд 2019 оны хүн амын жилийн асалтийн хувь өмнөх оноос 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.1. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Зураг 1. 4. Хүн ам зүйн үзүүлэлт, насны бүлгээр, 2010-2019 он



2019 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл нийт хүн амын 1 026.5 (32.1%) нь 15 хүртэлх насны хүүхэд, 2 034.7 (63.6%) нь 15-64 насны хүмүүс, 135.8 (4.2%) нь 65 ба түүнээс дээш насны өндөр настан байна.

Хүн ам зүйн насны бүтэц нь тухайн хүн амын өсөлт, хүн амын хөгжлийн түвшин, нийгмийн байдал зэргийг тооцоолоход чухал ач холбогдолтой үзүүлэлт юм. Тухайлбал, хөдөлмөрийн насанд байгаа үедээ 15-24 насныхан ихэнхи нь боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцдаг учраас тэжээлгэгч байдаг. Мөн хөдөлмөрийн насанд байгаа боловч тухайн үед ажил эрхлээгүй жирэмсэн, бага насны хүүхэд болон өндөр настанг асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй, ажиллах чадваргүй эсвэл ажилгүйчүүд гэх мэт тэжээлгэгчдийн тоо өсдөг.

Зураг 1. 5. Хүн ам зүйн ачаалал, 2010-2019 он



Хүснэгт 1. 1. Хүн амч зүйн ачаалал, улс, аймгаар, төрлөөр, 2010-2019 он

Хүн ам зүйн ачаалал		2010	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт	Өвөрхангай	56.9	49.4	49.8	50.2	52.7	52	52.9	54.7	55.8
	Улсын дүн	46.7	46.3	47	47.2	51.3	50.8	52	54.6	57.1
Хүүхэд	Өвөрхангай	50	42.9	43.3	43.8	46.1	45.4	46.1	47.8	48.4
	Улсын дүн	41.1	40.5	41.2	41.3	45.5	45	45.9	48.3	50.4
Хөгшид	Өвөрхангай	6.9	6.4	6.5	6.4	6.6	6.6	6.8	6.9	6.9
	Улсын дүн	5.6	5.8	5.8	5.8	5.8	5.8	6.1	6.3	6.7

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.mn

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15 хүртлэх, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг харуулдаг.

Хүснэгт 1. 2 Хүн ам зүйн ачаалал, сумдаар, 2010-2019 он


Засаг захиргааны нэгж		2010	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Өвөрхангай	56.9	49.4	49.8	50.2	52.7	52	52.9	54.7	55.8
2	Арвайхээр	57.2	50.5	51.8	49	53.4	52.5	54.8	57.6	60
3	Баруунбаян-Улаан	70.9	58.2	59.5	54.5	55.1	55.1	54.9	57.7	57
4	Бат-Өлзий	62.2	56.5	57.4	53.1	55.2	54.3	55	55.5	56.1
5	Баянгол	64.5	53.3	52.4	47.2	47.3	47.4	47.3	48	48.6
6	Баян-Өндөр	66.3	59.3	58.7	53.9	54.9	54.4	53.6	54.7	55.6
7	Богд	69.4	58.6	58.7	55.8	56.4	55.9	55.8	57.4	58.7
8	Бүрд	66.7	57.6	60.1	51.5	54.2	52.9	52.7	56.1	56.3
9	Гучин-Ус	69.9	57.3	57.3	50.3	52.5	49.9	48.5	50.8	51.2
10	Есөнзүйл	71.9	58.5	56.7	51.9	53.5	54.9	54.7	56.5	57.6
11	Зүүнбаян-Улаан	54.4	49.6	51.6	47	49.2	50.1	50.8	51.2	51.9
12	Нарийнтээл	60.9	50.5	49.2	44.7	46.3	45.7	45.9	48.9	50.4
13	Өлзийт	63.6	59.8	58.8	54.4	57.8	57.3	56.8	56.8	58.2
14	Сант	70.9	61.6	58.3	51.1	52.6	50.7	51.3	51.6	51.3
15	Тарагт	61	51.6	52.6	47.1	49.4	49.3	47.6	48.2	49.3
16	Төгрөг	61.5	55.1	54.4	50.8	51.5	51.2	51.9	52.1	51.5
17	Уянга	56.1	55.3	55.6	52.2	53.4	52.2	52	52.9	54.1
18	Хайрхандулаан	60.7	52.2	51.8	46.5	48.3	48.8	49.8	49.4	50.3
19	Хархорин	63.2	50	52	48	50.4	49.6	51.6	54.7	54.5
20	Хужирт	69	58.5	59.6	52.7	56.3	54.7	55.1	56.9	57.2

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.mn

Өвөрхангай аймгийн хүн ам зүйн ачаалал 2019 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 55.8 хүн ногдож байгаа нь 2010 онтой харьцуулахад 1.1-ээр буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны байдлаар Өвөрхангай аймгийн хөдөлмөрийн насны 100 хүнд 0-15 насны 48 тэжээлгэгч хүүхэд, 65 ба түүнээс дээш насны 6.9 ахмад настан тус тус ногдож байна.

Зураг1. 3 Хүн амын нягтрал, улс, аймгаар, 2010-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.mn

Хүн амын нягтрал нь нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлдэг бөгөөд энэхүү үзүүлэлт нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжинд нөлөөлж байдаг. Өвөрхангай аймгийн хүн амын нягтрал 2019 онд 1.9 байгаа нь улсын дунджаас 0.2 пунктээр доогуур үзүүлэлттэй байна.

Зураг 1. 4. Хүн амын нягтрал, сумдаар, 2010-2019 он

Засаг захиргааны нэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Арвайхээр	159.3	166.7	166	173.3	174.9	175.3	177.4	179.7	184.5	190.1
Баруунбаян-Улаан	0.63	0.69	0.66	0.66	0.67	0.69	0.7	0.7	0.7	0.7
Бат-Өлзий	2.49	2.8	2.58	2.76	2.97	2.99	3.04	3.1	3.1	3.1
Баянгол	0.89	1.16	1.13	1.1	1.07	1.08	1.09	1.1	1.1	1.1
Баян-Өндөр	0.96	1.27	1.26	1.21	1.19	1.17	1.17	1.2	1.2	1.1
Богд	0.49	0.53	0.52	0.53	0.53	0.54	0.55	0.6	0.6	0.6
Бүрд	0.94	1.17	1.17	1.14	1.1	1.1	1.13	1.1	1.1	1.1
Гучин-Ус	0.37	0.47	0.47	0.46	0.45	0.45	0.46	0.5	0.5	0.5
Есөнзүйл	1.09	1.48	1.46	1.41	1.39	1.36	1.39	1.4	1.4	1.3
Зүүнбаян-Улаан	1.3	1.53	1.49	1.57	1.48	1.44	1.49	1.5	1.5	1.4
Нарийнтээл	1.27	1.37	1.35	1.32	1.32	1.33	1.32	1.3	1.4	1.3
Өлзийт	0.99	1.45	1.25	1.23	1.39	1.31	1.35	1.4	1.4	1.3
Сант	1.16	1.23	1.28	1.32	1.44	1.36	1.39	1.4	1.4	1.4
Тарагт	0.89	0.94	0.88	0.89	0.94	0.95	0.98	1	1	0.9
Төгрөг	0.41	0.48	0.51	0.5	0.49	0.49	0.5	0.5	0.5	0.5
Уянга	3.27	3.06	2.97	2.96	2.97	2.99	3.02	3	3	3
Хайрхандулаан	0.7	0.82	0.8	0.81	0.81	0.81	0.84	0.8	0.9	0.8

Хархорин	4.72	5.63	5.48	5.46	5.6	5.37	5.54	5.6	5.6	5.5
Хужирт	3.44	3.92	3.98	3.9	3.8	3.83	3.88	3.9	4	3.9

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.mn

Хүн амын нягтрал 2019 оны байдлаар Арвайхээр суманд хамгийн их буюу 190.1 байгаа бол Төгрөг(0.5), Баруунбаян-улаан (0.7) сумдуудад хамгийн бага үзүүлэлттэй байна.

1.2. ТӨРӨЛТ

Төрөлт нь хүн амын өсөлт болон насны бүтцийн өөрчлөлтийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

2019 онд нийт 2586 эх төрсөн байгаа нь 10 жилийн өмнөхөөс 6.0 хувиар буурсан бол өмнөх оныхоос 8.4 хувиар өссөн байна. 2019 оны төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд 110 хөвгүүд ногдож байна.


Зураг1. 5. Төрөлт, амьд төрсөн нярайн тоо, сүүлийн 5 жилээр



Эх үүсвэр: Өвөрхангай аймгийн үйл ажиллагааны үндсэн тайлан, 2010-2019 он

Өвөрхангай аймгийн сүүлийн 10 жилийн байдлаарх нийт төрөлтийг харвал 2013 онд 2779 болж хамгийн их хүүхэд төрсөн байна.


Зураг1. 6 Төрөлтийн ерөнхий коэффициент



Төрөлтийн ерөнхий коэффициент нь тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Өвөрхангай аймгийн 2019 оны байдлаарх төрөлтийн ерөнхий коэффициент 22 байгаа нь 2019 оны улсын дунджаас 3 пунктээр, 10 жилийн өмнөх аймгийн дунджаас мөн 3 пунктээр тус бүр буурсан байна.


Зураг 1. 7. Төрөлтийн тусгай коэффициент



Төрөлтийн тусгай коэффициент нь тухайн жилийн төрөх насны (15-49) 1 000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь насны бүтцээс үл хамаарч, тухайн жилийн төрөлтийн дундаж түвшинг харуулдаг.

Өвөрхангай аймгийн 2019 оны байдлаарх төрөлтийн тусгай коэффициент 85 байгаа нь 2019 оны улсын дунджаас 9 пунктээр доогуур, 10 жилийн өмнөх аймгийн дунджаас 2 пунктээр өссөн байна


Зураг 1. 8. Төрөлтийн коэффициент, сумдаар, 2019 он



2019 оны байдлаарх ТТК нь Баруунбаян-улаан (103.7), Богд (102.1) суманд хамгийн их байгаа бол Есөнзүйл (45.6), Баян-өндөр(47.7) сумдуудад хамгийн бага үзүүлэлттэй байна.

2019 оны байдлаарх ТЕК нь Баруунбаян-улаан (27.0), Богд (27.1) суманд хамгийн их байгаа бол Есөнзүйл (11.2), Баян-өндөр(11.8) сумдуудад хамгийн бага үзүүлэлттэй байна.

Зураг1. 9. Төрөлтийн нийлбэр коэффициент



ТНК нь нэг эмэгтэйн (нөхөн үржихүйн амьдралын хугацаагаа дуустал нас барахгүй ба тухайн жилийн тухайн насны бүлэг дэх төрөлтийн түвшин хадгалагдана гэж үзвэл нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоог илэрхийлнэ.


ТНК-оор одоогийн төрөлт хүн ам тооны хувьд эргэн нөхөгдөх түвшингээ хангаж чадаж байгаа эсэхийг дүгнэж болдог. Төрөлт эргэн нөхөгдөх түвшинд байна гэдэг нь хүн ам дунджаар өөрсдийгөө “эргэн нөхөх” тооны хүүхэдтэй байхыг хэлэх бөгөөд энэ энэ түвшинг ТНК=2.1 үед хангагдана гэж үздэг. Хэрэв төрүүлсэн хүүхдийн тоо буюу ТНК дунджаар 2.0 байвал тэдгээр хүүхдүүд нөхөн үржихүйн насанд хүртлээ нас барахгүй байх үед эцэг, эхийгээ хоёуланг нь “нөхөж” чадна. Гэтэл амьдрал дээр төрсөн бүх хүүхдүүдээс зарим нь нөхөн үржихүйн насанд хүрэхээсээ өмнө нас бардаг, мөн шинээр төрж байгаа эмэгтэй хүүхдүүдийн тоо эрэгтэйгээсээ арай цөөн байдаг учраас ТНК нь 2.0-оос арай өндөр түвшинд буюу ойролцоогоор 2.1 байх үед хүн ам тооны хувьд эргэн нөхөгдсөөр байх боломжтой юм.

Өвөрхангай аймгийн хувьд сүүлийн жилүүдэд ТНК нь 2.1-ээс доогуур буюу хүн ам тооны хувьд эргэн нөхөгдөхгүй түвшинд байсан бол 2019 онд ТНК 2.1-д хүрч хүн ам тооны хувьд эргэн нөхөгдөх хэмжээнд хүрсэн байна.

1.3. ДУНДАЖ НАСЛАЛТ

Хүний амьдрах хугацааг тодорхойлох гол хэмжүүр нь "ДУНДАЖ НАСЛАЛТ" юм. Дэлхийн хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтын 2000 оноос хойшхи өсөлт нь өнгөрсөн зууны туршид гарсан үзүүлэлтийн хамгийн сайн буюу дундаж түвшинг давсан үзүүлэлт байсан байна.

Зураг1. 10. Дундаж наслалт, нийт, 2009-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.mn

Хүн амын тоо



58138

57599

Дундаж наслалт



73.78


68.1

Өвөрхангай аймгийн төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2009-2017 онуудад улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байсан бол 2018,2019 онуудад улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. 2019 онд 70.41 болж өмнөх оноос 0.2 пунктээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.96, эрэгтэйчүүдийнх 66.38 болсон байна.


Дундаж наслалт нь таамаглах хэмжигдэхүүн бөгөөд насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог.

Тухайн улсын хүн амын дундаж наслалтыг төрөлтөөс тооцсон дундаж наслалтаар тодорхойлдог. Дундаж наслалт нь хүйс, одоогийн нас, амьдралын хэв маяг зэргээс шалтгаалан ялгаатай байдаг.

Зураг 1. 11. Өвөрхангай аймгийн хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар




Зураг 1. 12. Дундаж наслалт, эрэгтэй, улс, аймгаар, 2009-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.тп

Өвөрхангай аймгийн 2019 оны байдлаарх эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.1 байгаа нь улсын дундажтай харьцуулахад 1.72 насаар, 10 жилийн өмнөх аймгийн дундаж наслалттай харьцуулахад 2.9 насаар тус бүр дээгүүр үзүүлэлттэй байна.


Зураг1. 13. Дундаж наслалт, эмэгтэй, улс, аймгаар, 2009-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.mn

Өвөрхөнгөй аймгийн 2019 оны байдлаарх эмэгтэйчүүдийн дундаж наслалт 73.78 байгаа нь улсын дундажтай харьцуулахад 2.18 насаар, 10 жилийн өмнөх аймгийн дундаж наслалттай харьцуулахад 3.13 насаар тус бүр дээгүүр үзүүлэлттэй байна.


Зураг1. 14. Дундаж наслалтын зөрүү, аймгуудаар, 2019 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн үзүүлэлт, ЭМХТ, 2019 он

Өвөрхөнгөй аймгийн 2019 оны байдлаарх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 5.7 байгаа нь улсын дунджаас 3.9-өөр бага буюу дундаж наслалтын зөрүү багатай аймгийн тоонд орж байна.

Зураг1. 15. Өвөрхангай аймгийн дундаж наслалтын зөрүү, 2010-2019 он




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- 1212.тп ашиглан үзүүлэлтийг тооцоолон гаргав.

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт наслах хандлага аль ч улсад байсаар ирсэн бөгөөд энэ нь эрүүл мэнд, нас баралт, нийгэм, эдийн засаг, тэгш бус байдал, эрүүл мэндийн систем, улс төр, байгаль орчин, газарзүйн байршил зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг байна. Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа нь аль ч улсад байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү амьдардаг байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Өвөрхангай аймгийн дундаж наслалтын зөрүү 2012, 2016, 2017 онуудад хамгийн бага буюу 5.3 байсан бол 2019 онд хамгийн их буюу 5.7 байна.

1.4. ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ



Хүн амын нас, хүйсийн бүтэц гэдэг нь тухайн нас, хүйсийн бүлэг дэх хүн амын тоо хэмжээний тархалтыг хэлдэг.

Нас, хүйсийн бүтцийн судалгаа нь тухайн хүн амын өнөөгийн байдал, түүнээс гарч болох үр дагавар, ирээдүйн төлвийг тодорхойлоод зогсохгүй цаашид баримтлах бодлого, төлөвлөлтийн үндэс суурь болдог байна.

Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг.

Өвөрхангай аймгийн хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн амын насны бүтэц идэрших хандлагатай байгааг харуулж байна. Харин 15-19 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1995 оноос хойш төрөлтийн түвшин буурч байсныг харуулж байна.

Аймгийн нийт хүн амын 63.3 хувь нь 35 хүртэл насны залуучууд байгаа нь улсын дунджаас 0.5 пунктээр доогуур үзүүлэлттэй байгаа хэдий ч харьцангуй идэр насны бүтэцтэй байгааг харуулж байна.

Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эерэгээр нөлөөлдөг. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдсэн гэж ойлгож болох юм.

БҮЛЭГ 2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (ТХЗ) нь олон улсын хөгжлийн талаар ирээдүйд биелүүлэхээр санал болгон дэвшүүлж буй багц зорилтууд юм.



Тогтвортой Хөгжлийн Зорилтууд нь олон улсын хөгжлийн талаар ирээдүйд биелүүлэхээр санал болгон дэвшүүлж буй багц зорилтууд юм. 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй Мянганы хөгжлийн зорилтуудын үргэлжлэл бөгөөд 2015 оны 9-р сард НҮБ-эндээд хэмжээний 70 дугаар чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг баталсан. Монгол Улсын ИХ Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг батлан гаргасан байна. Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016-2020, 2020-2025, 2025-2030 он гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэх юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд Монгол Улс ядуурлын бүх төрлийг эцэс болгож, монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг ханган дундаж наслалтыг 78-д хүргэнэ, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно гэж тооцсон байна. Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 3 дахь зорилго нь “Эрүүл амьдралыг хангах” буюу бүх түвшинд эрүүл амьдралыг хангаж, сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих зорилго тавьсан байна.

Тогтвортой хөгжлийн 17 зорилго

ТХЗ - 1 (7, 11) Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох	ТХЗ - 7 (5, 10) Тогтвортой, сэргээгдэх, орчин үеийн эрчим хүчээр хангах	ТХЗ - 13 (5, 8) Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх
ТХЗ - 2 (8, 12) Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангах, тогтвортой ХАА-г хөгжүүлэх	ТХЗ - 8 (12, 22) Тогтвортой эдийн засгийг дэмжих, ажлын байрыг бий болгох	ТХЗ - 14 (10, 20) Далай, тэнгисийг тогтвортой хөгжлийн зорилгоор ашиглах
ТХЗ - 3 (13, 26) Эрүүл амьдралыг хангах	ТХЗ - 9 (8, 22) Тогтвортой дэд бүтэц, шинэ технологи, үйлдвэржилтийг дэмжих	ТХЗ - 15 (12, 24) Экосистемийг хадгалах, цөлжилттэй тэмцэх, бэлчээрийн даацыг зөв зохистой ашиглах
ТХЗ - 4 (10, 15) Бүх нийтийн боловсролыг хөгжүүлэх, насан туршийн боловсролыг дэмжих	ТХЗ - 10 (10, 17) Улс орнуудын ялгаатай байдлыг бууруулах	ТХЗ - 16 (12, 21) Тогтвортой, бүх нийтийн оролцоог хангасан нийгмийг цогцлоох, шударга ёсыг дээдэлсэн нийгмийг хөгжүүлэх
ТХЗ - 5 (9, 23) Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах	ТХЗ - 11 (10, 20) Тогтвортой, аюулгүй хот сууринг бий болгох	ТХЗ - 17 (19, 38) Тогтвортой хөгжлийн төлөөх сайн түншлэлийг хөгжүүлэх
ТХЗ - 6 (8, 12) Ус болон ахуйн ариун цэврийн хэрэглээг хангах	ТХЗ - 12 (11, 21) Тогтвортой, зөв хэрэглээг бий болгох	

Шар: нийгмийн, Жөх: эдийн засгийн, Ногоон: байгалийн хөрөнгө, Ягаан: институцийн хөгжилд чиглэгдсэн болно.

Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 2020 он гэхэд 71-д хүргэх, 2025 онд 74, 2030 он гэхэд 78-д хүргэнэ гэж заасан байна.

Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

Энэхүү зорилтод 2020 гэхэд Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 25, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах.

2025 онд Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 20, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11 болгож бууруулах.

2030 онд сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 15, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах зорилтыг дэвшүүлсэн байна.

Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

2020 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах.

2025 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулах.

2030 онд 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.

Энэхүү зорилтод 2020 гэхэд товллолт дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14.4 болгон бууруулах.

2025 онд товллолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 болгон бууруулах.


2030 онд Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99.8, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болгон бууруулах зорилтыг дэвшүүлсэн байна.

ТХЗ 3.1.1. ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ХАРЬЦАА /100 000 АМЬД ТӨРӨЛТӨД/

Монгол Улсын Засгийн газраас баталсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн шалгуур үзүүлэлтэд эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эхийн эндэгдлийн харьцааг 2020 онд 25 болгож, бууруулахаар зорьсон.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 100 000 амьд төрөлтөнд ногдох эхийн эндэгдлийг тэглэх зорилт тавин ажиллаж байна.

Зураг 2. 1. Эхийн эндэгдлийн харьцаа, Өвөрхангай аймаг, 2010-2019 он



Өвөрхангай аймгийн хэмжээнд 100 000 амьд төрөлтөнд ногдох эхийн эндэгдлийн харьцаа сүүлийн 5 жилийн дунджаар 29.9 байгаа нь 5 жилийн улсын дунджаас 0.4 пунктээр доогуур буюу ойролцоо түвшинд байна.

ТХЗ 3.1.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН ЭХ БАРЬСАН ТӨРӨЛТИЙН ЭЗЛЭХ ХУВЬ


Эсэн мэнд амаржихад хамгийн чухал үүрэгтэй гол нөхцөл бол төрөлт бүрийг эх барихуйн ур чадвартай эмнэлгийн мэргэжилтэн эх барьж, яаралтай тусламж шаардлагатай

үед зохих шатны эх барихуйн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдсэн байх явдал юм. Эмнэлгийн мэргэжилтний эх барьсан төрөлтийн эзлэх хувь нь эхийн эндэгдлийг бууруулах гол шалгуур үзүүлэлт юм.

Эмнэлгийн төрөлтийн хувийн жинг нэмэгдүүлэх нь эх, нярайн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах нэг гол хүчин зүйл болдог. Төрөх үеийн эмнэлгийн тусламж, тоног төхөөрөмж, эрүүл ахуйн орчин нь эх, нярайн өвчлөл, нас баралтын шалтгаан, халдварын эрсдэлийг бууруулдаг.

Өвөрхангай аймагт 2019 оны жилийн эцсийн байдлаар 2586 эх төрснөөс гэрийн төрөлт 7 бүртгэгдэж нийт төрөлтийн 0.3 хувийг эзэлж байгаа нь улсын дундажтай ижил түвшинд байна. Эмнэлгийн мэргэжилтэн эх барьсан төрөлт 100 хувьтай байгаа бөгөөд энэ үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд тогтвортой байна.

Зураг 2. 2. Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн эзлэх хувь, 2010-2019 он



Эх сурвалж: Жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, Эрүүл мэндийн үзүүлэлт-2019 он, ЭМХТ

ТХЗ 3.7.2. ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ТӨРӨЛТИЙН ТҮВШИН /15-19 НАСНЫ ЭМЭГТЭЙД/

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент (НБТК) нь тухайн насны эмэгтэйчүүдэд ногдох төрөлтийн түвшин бөгөөд 15-19 насаар тооцсон үзүүлэлт нь ТХЗ-ын нэг шалгуур болох өсвөр насны охидын төрөлтийн түвшинг илтгэдэг.

Өсвөр насандаа хүүхэд төрүүлэх нь охидын хувьд нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг авчрах нь олонтой. Нийгэм дэх байр сууриа тодорхойлж, ирээдүйн амьдралынхаа эхлэлийг тавих насандаа хүүхэд төрүүлэх нь тэдний сурч боловсрох боломжийг багасгаж, улмаар нийгмээс тусгаарлагдмал, ядуурал болон хүчирхийлэлд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг байна. Хамгийн эрсдэлтэй зүйл нь өсвөр насны эхээс төрсөн хүүхэд өвчлөх, улмаар эндэх магадлал өндөр байдаг бол эх өөрөө жирэмсэн үедээ хүндрэлд өртөх, түүнийг даван туулах туршлага, бэлтгэл дутмаг байдгаасаа болоод нас барах тохиолдол ч түгээмэл гардаг.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар өсвөр насны охидын төрөлтийн түвшин тухайн насны 1000 эмэгтэйд харьцуулахад 36.6 байгаа нь 2015 онтой харьцуулахад 2.0-оор, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 0.84-өөр тус тус буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч 2019 оны улсын дундажтай харьцуулахад 5.8-аар өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 2.3. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, 2015-2019 он




ТХЗ 3.2.1. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН

Тогтвортой хөгжлийн зорилтод хүүхдийн эндэгдэл буюу нярай болон 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг зогсоохын тулд олон улсын хамтын нийгэмлэг цогц зорилтыг дэвшүүлсэн хэвээр байна. Нярайн эндэгдлийг 1 000 амьд төрөлт тутамд 12, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1 000 амьд төрөлт тутамд наад зах нь 25 хүртэл бууруулах уриалгыг дэлхийн хэмжээнд гаргасан бөгөөд эдгээр зорилтууд бүх улс орны үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгэн чухал зорилт байсаар байна.

Өвөрхангай аймаг нь 2024 гэхэд нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11.3 болгож бууруулах зорилтыг дэвшүүлсэн ба 2019 оны байдлаар нялхсын эндэгдлийн түвшин 14.9 байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 47.8 хувь нь нярай, 34.8 хувь нь 29 хоногтойгоос 1 хүртэлх настайдаа, 17.4 хувь нь 1-5 хүртэлх настайдаа эндсэн байна. Перинаталь эндэгдлийн 25 тохиолдол бүртгэгдэж, 1000 нийт төрөлтөд 9.6 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 тохиолдлоор буюу 3.0 промиллээр буурсан байна.


Зураг 2.4. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 2010-2019 он



2019 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 37 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 14.6 болсон нь 2010 онтой харьцуулахад 13.7 пунктээр, 10 жилийн дундажтай харьцуулахад 4.0 пунктээр тус тус буурсан байна. 2019 оны

байдлаар нялхсын эндэгдлийн 18.4 хувь нь гэртээ, 81.6 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 32.3 хувь нь хоног болоогүй нас баралт эзэлж байна.


Зураг 2.5. Нялхсын эндэгдлийн түвшин, 2010-2019 он



ТХЗ 3.2.2а НЯРАЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН


2019 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд нярайн эндэгдлийн 22 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 8.4 болсон нь 2010 онтой харьцуулахад 5.8 пунктээр, 10 жилийн дундажтай харьцуулахад 3.1 пунктээр тус тус буурсан байна. 2019 онд бүртгэгдсэн нярайн эндэгдлийн бүх тохиолдол нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 31.8 хувь нь хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Зураг 2.6. Нярайн эндэгдлийн түвшин, 2010-2019 он



2019 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд перинаиаль эндэгдлийн 25 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 9.6 байгаа нь 2010 онтой харьцуулахад 9.8 пунктээр, 10 жилийн дундажтай харьцуулахад 4.6 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 2.7. Амьгүй төрөлт, перинаталь эндэгдэл, 1 000 нийт төрөлтөд, 2010-2019 он



2019 онд аймгийн хэмжээнд амьгүй төрөлтийн 9 тохиолдол бүртгэгдэж 1000 нийт төрөлтөд 3.4 ногдож байгаа нь 2010 онтой харьцуулахад 6.3 пунктээр, 10 жилийн дундажтай харьцуулахад 3.0 пунктээр тус тус буурсан байна.

ТХЗ 3.3.1. ХДХВ-ИЙН ХАЛДВАРЛААГУЙ 1000 ХҮН АМД НООГДОХ ХДХВ-ИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТОО

1992 онд Монгол Улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2019 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 286 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 18 тохиолдол нь 2019 онд шинээр бүртгэгдсэн байна.


Өвөрхангай аймгийн хэмжээнд ХДХВ-ийн өвчлөл, нас баралт бүртгэгдээгүй байна. 2019 онд шинээр хяналтанд орсон 2718 жирэмсэн эхийн 2583 (95.0%)-д нь ХДХВ илрүүлэх шинжилгээг хийсэн байна.

ТХЗ 3.3.2. СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ТОХИОЛДЛЫН ТҮВШИН

Дэлхийн бусад улс орнуудын адил Монгол Улс 1996 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлснээр сүрьеэгийн шинээр илэрсэн тохиолдол 1996 оноос хойш тасралтгүй нэмэгдээд 2007 оноос буурах хандлага ажиглагдаж байна.

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д 2020 гэхэд сүрьеэгийн тохиолдлыг 144 болгон бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Зураг 2.8. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 2010-2019 он



2019 онд шинээр бүртгэгдсэн 58 тохиолдлын 27 (46.6%) нь уушгины сүрьеэ, 31 (53.4%) нь уушгины бус эрхтний сүрьеэ байгаа ба 2018 онтой харьцуулбал уушгины сүрьеэ 5 тохиолдлоор нэмэгдэж, уушгины бус эрхтний сүрьеэ 13 тохиолдлоор нэмэгдсэн ба уушгины сүрьеэгийн эзлэх хувь 8.6%-р буурч, уушгины бус эрхтний сүрьеэгийн эзлэх хувь 8.4%-аар нэмэгдсэн байна.

Өвөрхангай аймагт 2019 онд бүртгэгдсэн сүрьеэгийн өвчлөл нь амьсгалын замын халдварт өвчний 26.9 хувь, нийт халдварт өвчний 6.5 хувийг эзэлж байна.

2019 онд аймгийн хэмжээнд 0-18 насны 6 хүүхэд шинэ сүрьеэгээр өвчилж нийт сүрьеэгийн 10.3 хувийг эзэлж байгаа нь 2015 онтой харьцуулахад 3.8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

ТХЗ 3.3.4. В ВИРУСТ ХЕПАТИТ ӨВЧНИЙ ТОХИОЛДЛЫН ТҮВШИН

Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулахаар зорилт тавин ажиллаж байна.

Өвөрхангай аймагт 2019 оны байдлаар гепатитийн вирусийн цочмог халдварын 8 тохиолдол бүртгэгдсэнээс 87.5 хувийг гепатитийн В вирусийн халдвар, 12.5 хувийг гепатитийн бусад вирусийн халдвар тус тус эзэлж байна.

2019 оны байдлаар гепатитийн В вирусийн халдварын 8 тохиолдол бүртгэгдэж, 100 000 хүн амд 6.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр өссөн байна.

Зураг 2. 9. Вируст гепатитын өвчлөлийн түвшин, 2010-2019 он



ТХЗ 3.4.1. ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧИН, ХАВДАР, ЧИХРИЙН ШИЖИН АМЬСГАЛЫН ЗАМЫН АРХАГ ӨВЧНӨӨС ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТҮВШИН /30-70 НАСНЫ 10 000 ХҮН АМД/


2016 онд дэлхийн хэмжээнд нас баралтын шалтгааны 71 хувь нь халдварт бус өвчнөөр, түүнээс 15 сая буюу 85 хувь 30-70 насны хүн амын нас баралт эзэлж байна.

Дэлхий даяар 2016 онд 30-аас 70 насны хүн амын халдварт бус өвчний үндсэн 4 шалтгаан болох зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал 2000 онд 22 хувь байсан бөгөөд 2010 онд 19 хувь, 2016 онд 18 болж буурчээ. Өвөрхангай аймгийн хувьд нийт 30-70 насныхны нас баралт нийт нас баралтын 53.5 хувийг эзэлж байна.


Зураг3.3. 1. 30-70 насны хүн амын зүрх судасны өвчний шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүн амд, 2014-2019 он



Зураг3.3. 2. 30-70 насны хүн амын хорт хавдрын шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүн амд, 2014-2019 он



Зураг3.3.3. 30-70 насны хүн амын чихрийн шижин өвчний шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүн амд, 2014-2019 он



2019 онд зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын 398 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 67.8 хувийг эзэлж улсын үзүүлэлтээс 5.8 пунктээр өндөр байгаа ба 56.0 хувь нь 30-70 насныхан байгаа нь улсын дунджаас 4.7 пунктээр бага хувийг эзэлж байна. Халдварт бус өвчний шалтгаант нас баралтын дараах 4 өвчлөл 30-70 насныханд тухайн насны 10 000 хүн амд харьцуулахад зүрх судасны өвчлөлийн шалтгаант нас баралт аймгийн дундаж 22.7 ба улсын дунджаас

5.4 пунктээр, аймгийн хэмжээнд хавдар 17.5 ногдож улсын дунджаас 3.2 пунктээр, аймгийн хэмжээнд амьсгалын замын архаг өвчин 1.9 ногдож улсын дунджаас 0.8 пунктээр, чихрийн шижин 1.2 ногдож улсын дунджаас 0.4 пунктээр тус тус өндөр түвшинд байна. 2010-2019 оны мэдээллээс харахад зүрх судасны өвчний шалтгаант нас баралт буурах хандлагатай харагдаж байгаа бол хавдар, чихрийн шижингийн нас баралт нэмэгдэх хандлагатай байна.


Эдгээр өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин 30-70 насны эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс харьцангуй өндөр байгаа ба тухайн насны 10 000 хүн амд харьцуулахад өндөр байна.

ТХЗ 3.4.2 АМИА ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН (100,000 ХҮН АМД)

Амиа хорлолт нь дэлхийн нийтийн эрүүл мэндийн ноцтой асуудал болж байгаа бөгөөд дэлхий даяар нас баралтын тэргүүлэх хорин шалтгаанд багтаж, хумхаа, хөхний хорт хавдар, дайн байлдаан болон хүчирхийллийн шалтгаанаас илүү тохиолдол бүртгэгдэж байна. Жил бүр 800,000 орчим хүн амиа хорлож нас барж байгаа ба энэ шалтгааныг бууруулах асуудлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) дэлхий нийтийн зорилт болгосон төдийгүй Тогтвортой хөгжлийн зорилтын 3.4 зорилт болгон дэвшүүлээд байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 643 орчим хүн нас барснаас 2.7% орчим хувь нь амиа хорлон нас барсан нь улсын дунджаас 0.1 пунктээр бага түвшинд байна. 2010 оны байдлаар амиа хорлосон нас баралт 100 000 хүн тутамд 10.7 буюу улсын дунджаас 6.8 пунктээр бага түвшинд байсан бол 2019 онд 12.9 болж улсын дунджаас 1.1 пунктээр бага байна. Аймгийн хэмжээнд амиа хорлолтыг хүйсээр авч үзвэл: 2010-2019 оны дунджаар амиа хорлогчдын 86.0 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг3.3. 4. Амиа хорлож нас барсан тохиолдол, 100 000 хүн амд, 2010-2019




Амиа хорлогчдын тоо 2019 онд 17 байгаа нь нийт нас баралтын 2.9 хувийг эзэлж байгаа эт улсын дунджаас 0.3 пунктээр бага ба аймгийн нас баралтыг сүүлийн 10 жилийн дундажтай эмэгтэйчүүд 2 тохиолдлоор, эрэгтэйчүүдийн нас баралт 4 тохиолдлоор тус тус буурсан байна.

Зураг3.3. 5. Амиа хорлож нас барсан тохиолдол, хүйсээр, Өвөрхангай аймаг, 2010-2019 он

ТХЗ 3.6.1 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТҮВШИН (100 000 ХҮН АМД)


Сүүлийн 10 жилийн хугацаанд осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 847 тохиолдол бүртгэгдсэн ба 30.3 хувийг зам тээврийн осол эзэлж улсын 10 жилийн дунджаас 6.7 пунктээр их байна.

Зураг3.3. 6. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 100 000 хүн амд, 2010-2019 он



Өвөрхaнгай аймагт зам тээврийн ослын шалтгаанаас сүүлийн 10 жилийн дунджаар жилд 27 хүн нас барсан байна. 2019 онд 17 хүн зам тээврийн ослоор нас барсан нь сүүлийн 10 жилийн дундажаас 9, өмнөх оноос 13 тохиолдлоор тус тус буурсан байна. Эрэгтэйчүүдийн зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс 5.4 дахин их байна.

Зураг3.3. 7. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 100 000 хүн амд, Өвөрхaнгай аймаг, хүйсээр, 2010-2019 он



БҮЛЭГ 3

3.1. ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын Засгийн Газраас 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2021 онуудад Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулах юм.

Зураг3. 1 Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, улс, аймгаар, 2010-2019 он



2017, 2018 онуудад эхийн эндэгдэл бүртгэгдээгүй бол 2019 онд эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 38.4 болж улсын дунджаас 15.4 пунктээр өндөр үзүүлэлттэй байна.

3.2. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ БА ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Жирэмсэн үеийн хяналт нь эх, ургийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлт хүчин зүйлүүдийг цаг алдалгүй илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эсэн мэнд амаржуулах, төрсний дараах үед тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд чиглэгддэг нэн чухал тусламж үйлчилгээ юм.

ДЭМБ-аас жирэмсэн үеийн хяналтад наад зах нь найман удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгосон ба цусны даралт хэмжих, шээсэнд бактери, уураг илрүүлэх шинжилгээ, тэмбүү болон хүнд хэлбэрийн цус багадалтыг илрүүлэх цусны шинжилгээ, жин/өндрийн хэмжилт зэрэг тусгайлсан үйлчилгээг зөвлөмж болгодог.

Жирэмсний хяналтад аль болох эрт орох нь илүү ач холбогдолтой бөгөөд жирэмсний эхний гурван сартайдаа хяналтад орсноор эх, хүүхдийн аль алиных нь эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Жирэмсний хяналт нь жирэмсний нийт хугацааны турш үргэлжилнэ.

Түүнчлэн, жирэмсний хяналтын үеэр нялхас эсэн мэнд төрж, өсөхөд нөлөө үзүүлдэг хүчин зүйл болох төрөлт хоорондын зайн талаар мэдлэг мэдээллийг олгодог. Дархлаажуулалт нь эх хүүхэд эсэн мэнд амаржихад чухал ач холбогдолтой. Жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсэн үеийн цус багадалтыг эрт илрүүлж эмчилснээр эхийн эрүүл мэнд сайжирч, нялхас эсэн мэнд мэндэлнэ.

Цаашлаад эхийн хоол тэжээлийн байдлыг дээшлүүлэх, БЗДХ болон бусад халдвараар өвчлөхөөс зайлсхийх зэргээр бага жинтэй хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх хосолсон арга хэмжээ авах нөхцөл бүрддэг. Мөн сүүлийн үед ХДХВ эхээс хүүхдэд дамжин халдварлахаас сэргийлэхийн тулд жирэмсний хяналтын үеийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах боллоо.

Манай улсад хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг 6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг бөгөөд эх жирэмсэн болсноо мэдмэгц 12 долоо хоногоос дотогш хугацаанд эхний үзлэгт хамрагдахыг шаарддаг.

Зураг3.2.1.Жирэмсний эрт үеийн хяналтын хувь, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд 2718 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд 90.6 хувь нь жирэмсний эрт үедээ хамрагдсан нь улсын дунджаас 1.9 хувиар их байна.

Өвөрхангай аймгийн жирэмсний эрт үеийн хяналтын хувь сүүлийн 10 жилийн дунджаар 86.6 байгаа нь улсын дунджаас 0.1 пунктээр их байна.

Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 95.5 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдсанаас 3.3 хувь нь цус багадалттай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар, 2019 оны улсын дундажтай харьцуулахад 0.2-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Баян-өндөр(4.9), Бүрд(4.3), Гучин-ус(4.0), Зүүнбаян-улаан(10.1), Уянсэтгэл(12.6), Энэрэл-Хархорин(10.4) зэрэг сум, өрхүүдэд аймгийн дунджаас 1.0-9.3 хувиар их байна.

Зураг3.2.2.Жирэмсний эрт болон хожуу үеийн хяналт, Өвөрхангай, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд 2 718 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа 90.6 хувь нь хамрагдсан нь 2010 онтой харьцуулахад 6.5 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 4.1 пунктээр тус тус дээгүүр үзүүлэлттэй байна. Жирэмсний хяналтын 8.8 хувь нь 4-6 сартайдаа, 0.6 хувь нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ.

Зураг3.2.3. Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2019 он



Эх үүсвэр: Жилийн эцсийн сарын мэдээ, 2019он


Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд 95.0 хувь хамрагдсанаас 1.4 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн байна.

Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 81.2 хувь нь хамрагдсан. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.2 хувьд нь заг хүйтэн өвчин илэрчээ.

Трихомониаз илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 81.2 хувь нь хамрагдсан. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.2 хувьд нь трихомониаз өвчин илэрчээ.

2019 оны байдлаар эхчүүдийн амрах байранд нийтдээ 41 ортой, 19 байр байгаагаас 26.3 хувь нь зориулалтын байранд байгаа ба 3837 ор хоног ашигласан байна. 2019 онд 1 байранд засвар хийж, 4 байранд тохижилт хийсэн байна. 2019 онд аймгийн хэмжээнд амарвал зохих эх 820 байснаас 618 буюу 75.4 хувь нь амрах байраар үйлчлүүлсэн нь улсын дунджаас 3.1 пунктээр дээгүүр үзүүлэлттэй байна.

Зураг3.2.3. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, сумдаар, 2019



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 2586 эх төрснөөс 1864 эх 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдаж 72.1 хувийг эзэлж байгаа бөгөөд БОЭТөв, Зүүнбаян-улаан сум аймгийн дунджаас 4.9-12.1 пунктээр доогуур үзүүлэлттэй байна. Нийт 12 суманд жирэмсэн эхийг 6 ба түүнээс дээш удаагийн хяналтанд бүрэн хамруулсан байна.

Зураг.3.2 1.15-19 насны өсвөр насны охидын төрөлтийн түвшин, тухайн насны 1000 эмэгтэйд, 2010-2019




3.3. ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ


Сүүлийн 10 жилд аймгийн хэмжээнд нийт 26178 эх амаржиж, 26420 хүүхэд төрүүлсний 26258 нь амьд төрөлт, 162 нь амьгүй төрөлт байна.

Сүүлийн 5 дунджаар амьд төрөлт 2573.2 байгаа нь өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 105.2 төрөлтөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Сүүлийн 5 жилийн дунджаар нийт төрөлтийн 0.5 хувийг амьгүй төрөлт эзэлж, өмнөх 5 жилийн дундажаас 0.2 пунктээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 1 000 нийт төрөлтөд ногдох амьгүй төрөлтийн түвшинг сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл 4.8 болж улсын дундажаас 1.2-оор, аймгийн 2010-2014 оны дунджаас 2.4-өөр тус тус буурсан байна.

Зураг3.3.8. 1 000 хүн амд ногдох төрөлтийн түвшин




Зураг3.3. 9 Төрөлтийг удирдсан эмч, сувилагч төрлөөр, 2015-2019 он



2019 оны байдлаар эх барих эмэгтэйчүүдийн их эмч төрөлт удирдсан хувь 90.8 хувьтай байгаа нь 2015 онтой харьцуулахад 4.5 пунктээр нэмэгдсэн бол их эмч удирдсан хувь 6.7 хувийг эзэлж, 2015 онтой харьцуулахад 1.8 пунктээр буурсан байна.

Зураг3.3. 10 Төрөлтийн дараалал, Өвөрхангай аймаг, 2015-2019 он




2019 оны байдлаар нийт төрөлтөөс 2 дахь удаагаа төрсөн эхчүүдийн эзлэх хувь хамгийн их буюу 29.4 байгаа нь сүүлийн 5 жилийн дунджаас 0.1 пунктээр, 2015 онтой харьцуулахад 2.4 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна.

Зураг3.3. 11. Дутуу төрсөн эх тохиолдлын тоо, харьяаллаар, 2015-2019 он

	2015	2016	2017	2018	2019
Баруунбаян-Улаан	3	3	4	4	3
Бат-Өлзий	6	11	8	3	5
Баянгол	6	2	3	3	2
Баянөндөр	5	2	2	2	1
Богд	2	7	3	5	6
Бүрд	1	4		1	1
Гучин-ус	1	2	3	3	3
Есөнзүйл	4	3	1	3	1
Зүүнбаян-Улаан	3	3	3	6	3
Нарийнтээл	4	4	4	3	3
Өлзийт	2	2	2	1	2
Сант	1	0	1	4	2
Тарагт	5	4		4	2
Төгрөг	6	4	4	1	5
Уянга	10	10	6	10	6
Хайрхандулаан	1	3		3	10
Хархорин	1	2	3	2	3
Хужирт	6	6	5	5	1
Уянсэтгэл	8	8	13	14	6
Түшиндөлгөөн	12	9	9	11	9
Нарны дөш	10	10	8	9	10
Энэрэл-Хархорин	4	8	4	3	7
Харъяаллын бус	9	7	6	11	5
Аймгийн дүн	110	114	92	111	96

2019 оны байдлаар 2586 эх төрснөөс 96 буюу 3.7 хувь нь 37-оос доош долоо хоногтойдоо төрж өмнөх оноос 0.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


Зураг3.3. 12. Дутуу төрсөн эх, нийгмийн байдал, 2015-2019 он



2019 оны байдлаар дутуу төрөлтийн 96 тохиолдол бүртгэгдэж сүүлийн 5 жилийн дунджаас 8 тохиолдлоор буурсан байна. Сүүлийн 5 жилд дутуу төрсөн эхчүүдийг нийгмийн

байдлаар авч үзвэл ажилгүй 34.2%, малчин эмэгтэйчүүд 33.1%, албан хаагч 6.0%, оюутан 5.8%, бусад 5.6%, 0-15насны хүүхэд 0.4 хувийг тус тус эхэлж байна.

Зураг3.3. 13. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, бодит тоогоор, Өвөрхангай



2019 оны байдлаар жирэмсэн, төрөлттэй холбоотой хүндрэлийн 42.0 хувийг жирэмсний үеийн хүндрэл, 51.4 хувийг төрөх үеийн хүндрэл, 6.6 хувийг төрсний дараах үеийн хүндрэл эзэлж байна.


Зураг3.3. 14. Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, улс, аймгаар, 2011-2019 он



Эх үүсвэр: Hinfo-3 программ, Эрүүл мэндийн үзүүлэлт 2019 он

ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг. Манай аймгийн хувьд 2019 оны байдлаар харьцангуй өндөр буюу 24.9 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлж улсын дунджаас 1.1пунктээр бага байна. Мэс заслын аргаар төрсөн эхийн тоог өмнөх онтой харьцуулахад 58 тохиолдлоор буюу 9.8 хувиар өссөн байна. 2019 оны байдлаар мэс заслын аргаар төрлөгийг шийдсэн хувийг эмнэлгийн төрлөөр авч үзвэл 83.8 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 14.8 хувь нь Хархорин нэгдсэн эмнэлэгт, 1.4 хувь нь Батэлзий, Богд, Нарийнтээл, Уянга, Хужирт сумын эрүүл мэндийн төвүүдэд тус тус хийгдсэн байна.


Зураг3.3.15. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, эзлэх хувиар



Өвөрхангай аймагт 2019 оны байдлаар жирэмсэн үеийн, төрөх болон төрсний дараах үеийн нийт 1134 хүндрэл бүртгэгдэж нийт төрөлтийн 43.9 хувийг эзэлж байна. 2019 оны жирэмсний хүндрэлтэй төрсөн эхчүүдийг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 299 тохиолдлоор, 2010 онтой харьцуулахад 77 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны жирэмсний хүндрэлтэй төрсөн эхчүүдийг эмнэлгийн төрлөөр авч үзвэл 90.6 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 7.8 хувь нь Хархорин нэгдсэн эмнэлэгт, 1.6 хувь нь сумын эрүүл мэндийн төвүүдэд бүртгэгдсэн байна.

Зураг3.3.16. Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь,2012-2019 он



Өвөрхангай аймагт 2019 оны байдлаар жирэмсний хүндрэлд манас таталт 24.8 хувийг эзэлж байгаа нь 2012 онтой харьцуулахад 58.1 пунктээр буурсан хэдий ч сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 6.3 пунктээр өссөн байна.

Зураг3.3. 17. Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, 2012-2019он



Өвөрхангай аймагт 2019 оны байдлаар төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулрал 48.7 хувийг эзэлж байгаа нь 2012 онтой харьцуулахад 11.0 пунктээр, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 3.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

3.4. ТӨРСНИЙ ДАРААХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Төрөх болон төрсний дараах богинохон үе бол эх, хүүхдийн эрүүл мэнд, амь насанд онцгой нөлөөтэй мөч байдаг. Дэлхий дээр жил бүр ойролцоогоор 3 сая хүүхэд төрсний дараах сарын хугацаанд эндэж, эндэгдлийн дийлэнх нь эхний 1-2 хоногт тохиолдож байна. Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 1134 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 435 ногдож улсын дунджаас 277 пунктээр доогуур үзүүлэлттэй байна. Нийт хүндрэл дотор:


- Жирэмсэн үеийн хүндрэл- 42.0 хувь (улсын дундаж-43.5 хувь)
- Төрөх үеийн хүндрэл-51.4 хувь (улсын дундаж-54.0 хувь)
- Төрсний дараах үеийн хүндрэл- 6.6 хувь (улсын дундаж-2.5 хувь)-г тус тус эзэлж байна.

Зураг3.4. 1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн хувь, эрүүл мэндийн байгууллагаар, Өвөрхангай, 2010 он




2010 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн эзлэх хувь Хархорин нэгдсэн эмнэлэгт 21.1 хувь, Сумын эрүүл мэндийн төвүүдэд 12.7 хувь байгаа нь 2019 онтой харьцуулахад 11.1-13.3 пунктээр их байна.

Зураг3.4. 2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн хувь, эрүүл мэндийн байгууллагаар, Өвөрхангай, 2019 он



Аймгийн хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн жирэмсний хүндрэлийн 90.6 хувь нь БОЭТ-д бүртгэгдэж 2010 онтой харьцуулахад 24.4 хувиар өссөн, 7.8 хувь нь ХХНЭ-т бүртгэгдэж 2010 онтой харьцуулахад 13.3 хувиар буурсан, 1.6 хувь нь СЭМТ-д бүртгэгдэж 2010 онтой харьцуулахад 11.1 хувиар буурсан өөрчлөлттэй байна.

Зураг3.4. 3. Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь




2019 оны байдлаар төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь 97.3 байгаа нь улсын дунджаас 12.6 пунктээр, аймгуудын дунджаас 13.3 пунктээр тус тус өндөр үзүүлэлттэй буюу цус алдалтын шалтгаант хүндрэл их байна. 2019 оны аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 45.4 хувиар их, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 32.5 хувиар тус тус өндөр үзүүлэлттэй байна.

3.5. ТӨРСӨН НЯРАЙН МЭДЭЭЛЭЛ

Сүүлийн 10 жилийн байдлаар нийт төрөлтийг харвал 2013 онд 2801 болж, хамгийн их хүүхэд төрсөн байна. 2019 онд нийт 2614 хүүхэд төрж 10 жилийн өмнөхөөс 6.0 хувиар, 5 жилийн өмнөхөөс 5.7 хувиар тус тус буурсан байна. Харин өмнөх оноос 8.2 хувиар нэмэгджээ.

Зураг3.5. 1 Төрсөн хүүхдийн тоо, Өвөрхангай, 2010-2019 он



Сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн олон төрөлт 2013 онд бүртгэгдэж 2783 хүүхэд төрсөн бол, 2018 онд төрөлт хамгийн бага буюу 2403 хүүхэд мэндэлсэн байна.


Зураг3.5. 2.Төрөлтийн тоо, эрүүл мэндийн байгууллагаар, сумдаар, 2015-2019 он

	2015	2016	2017	2018	2019
Баруун-БаянУлаан	11	6	6	5	5
Бат-Өлзий	84	66	65	62	26
Баянгол	11	9	7	9	4
Баян-Өндөр	5	11	7	3	4
Богд	39	53	35	44	59
Бүрд	18	27	14	15	15
Гучин-Ус	3	7	13	8	5
Зүйл	14	14	21	7	11
ЗБУ	21	16	9	2	10
Нарийнтээл	15	17	10	6	11
Өлзийт	7	11	4	7	3
Сант	26	10	8	8	9
Тарагт	3	9	2	1	3
Төгрөг	8	6	7	5	2
Уянга	107	81	96	81	50
Хайрхан-дулаан	11	35	21	21	10
Хархорин	296	283	279	255	297
Хужирт	90	67	42	88	52
Уянсэтгэл	0	1	0	0	0
Түшигдөлгөөн	0	0	0	1	0
Нарны дөш	0	0	0	0	0

Энэрэл-Хархорин	0	0	0	0	0
Асар хайрхан	15	13	5	4	0
БОЭТ	1957	1922	1766	1772	2010
Нийт	2741	2664	2417	2404	2586

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 2586 эх төрснөөс 77.7 хувь нь, 2018 онд 73.7 хувь нь, 2017 онд 73.1 хувь нь, 2016 онд 72.1 хувь нь, 2015 онд 71.4 хувь нь тус тус Бүсийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд төржээ. Сүүлийн жилүүдэд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд төрсөн эхийн эзлэх хувь нэмэгдсэн бөгөөд сумын эрүүл мэндийн төвүүдэд нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нэмэгдүүлэх, чадавхжуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зураг3.5.3. Төрөх үеийн хүйсийн харьцаа



Төрөх үеийн хүйсийн харьцаа нь тухайн жилийн амьд төрсөн 100 эмэгтэй хүүхэд тутамд ногдох амьд төрсөн эрэгтэй хүүхдийн тоог илэрхийлнэ.

Манай аймагт хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 2019 онд 100 охинд ойролцоогоор 107 хөвгүүн ногдож улсын дунджаас 1.6-аар их байна.

Зураг3.5.4.Төрөх үеийн хүйсийн харьцаа, сумдаар, 2010-2011, 2013-2019 он

Сумын нэр	2010	2011	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Арвайхээр	113.1	96.2	97.1	96.5	96.5	116.7	95.5	113.5	106.8
Баруунбаян-Улаан	70.6	86.9	103.3	84.9	84.9	84	125	63.4	108.1
Бат-Өлзий	108.1	80	100	153.3	153.3	100	135.5	104.3	96.7
Баянгол	51.9	100	70.2	100	100	114	80.9	102.4	92.3
Баян-Өндөр	98	119.1	109.3	184.8	184.8	93.6	104.8	184.6	135
Богд	110.7	171.2	104.5	94.4	94.4	156.7	93.9	90.8	114.1
Бүрд	85	121.9	80	100	100	88.9	125	117.1	89.5
Гучин-Ус	107.7	84.6	92.9	84.4	84.4	92.6	114.3	107.4	186.4
Есөнзүйл	87.5	131	110.8	116.7	116.7	128.6	110	100	77.1
Зүүнбаян-Улаан	96	100	123.5	78.7	78.7	135.4	104.9	150	131.8
Нарийнтээл	88.9	92.2	79.6	111.6	111.6	116.7	134.3	125.7	92.2
Өлзийт	128	93.9	181.8	109.3	109.3	71.4	90.9	86.5	114.8


Сант	144.8	117.1	114.3	93.9	93.9	119.4	102.9	100	118.6
Тарагт	53.7	135.7	129.6	78.3	78.3	110	82.8	148.5	120
Төгрөг	137.9	92.1	121.9	109.1	109.1	65.2	68.6	147.8	109.7
Уянга	87.6	93	128.3	96.3	96.3	109.9	119.4	98.4	102.3
Хайрхандулаан	111.8	90.7	95	112.8	112.8	80	102.3	87.2	135.9
Хархорин	94.7	45	120.4	101.4	101.4	98.7	107.7	116.8	89.5
Хужирт	142.9	124.3	106.7	120	120	91.5	137	93.4	125.8

Эх үүсвэр: Мэдээллийн нэгдсэн сан-1212.mn

2019 оны төрөх үеийн хүйсийн харьцааг сумаар авч үзвэл Гучин-ус суманд хамгийн их зөрүүтэй 100 охинд 186 хөвгүүн ногдож байгаа бол Есөнзүйл суманд 100 охинд 77 хөвгүүн ногдож байна. 2010 оны төрөх үеийн хүйсийн харьцааг сумаар авч үзвэл Сант суманд хамгийн их зөрүүтэй буюу 100 охинд 144.8 хөвгүүн ногдож байсан бол Баянгол суманд 100 охинд 51.9 хөвгүүн ногдож байна.

2019 онд Өвөрхангай аймгийн төрөлтийн түвшин 1000 хүн амд 22.5 байгаа нь улсын дунджаас 2.0 -оор бага байна.

Зураг3.5.5. Бага жинтэй /2500гр-аас доош/ төрсөн хүүхдийн тоо, хувь, 2010-2019 он



Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар амьд төрсөн хүүхдийн 3.8 хувь нь 2500 грамаас доош жинтэй төрж, улсын дунджаас 0.6 хувиар, Өвөрхангай аймгийн сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 0.3 хувиар бага байна.

Зураг3.5.6.Хүүхдийн жин, байгууллагын төрлөөр, 2019 он


Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Амьд төрсөн эсэх	Хүйс	Бүгд	2500грамм-аас доош жинтэй	2500-2999 грамм	3000-3499 грамм	3500-3999 грамм	4000грамм-аас дээш жинтэй
Бүсийн эмчилгээ, оношлогооны төв	Амьд төрсөн	Эр	1065	46	142	449	344	84
		Эм	965	36	184	433	270	42
	Амьгүй төрсөн	Эр	4	3	1	0	0	0
		Эм	3	3	0	0	0	0
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	Амьд төрсөн	Эр	146	5	19	58	44	20
		Эм	149	2	20	59	60	8
		Эр	2	2	0	0	0	0

	Амьгүй төрсөн	Эм	0	0	0	0	0	0
Сумын эмнэлэг	Амьд төрсөн	Эр	151	6	26	63	41	15
		Эм	129	4	29	51	38	7
	Амьгүй төрсөн	Эр	0	0	0	0	0	0
		Эм	0	0	0	0	0	0
Нийт дүн	Амьд төрсөн	Эр	1362	57	187	570	429	119
		Эм	1243	42	233	543	368	57
	Амьгүй төрсөн	Эр	6	5	1	0	0	0
		Эм	3	3	0	0	0	0

Аймгийн хэмжээнд 2019 онд амьд төрсөн нярайн жинг хүйсээр харьцуулан харвал: төрсөн эрэгтэй нярайн 4.2 хувь нь 2500 гр-аас бага жинтэй, 13.7 хувь нь 2500-3000 гр жинтэй, дийлэнх нь буюу 73.4 хувь нь 3000-4000 гр жинтэй, 8.7 хувь нь 4000 гр-аас дээш жинтэй төрсөн байна. Харин эмэгтэй нярайн 3.4 хувь нь 2500 гр-аас бага жинтэй, 18.7 хувь нь 2500-3000 гр жинтэй, 73.3 орчим хувь нь 3000-4000 гр жинтэй, 4.6 хувь нь 4000 гр-аас дээш жинтэй төрсөн байна.

3.6.Амьгүй төрөлт

Зураг3.6.1.Амьгүй төрөлтийн түвшин, улс, аймгаар, 2010-2019 он



2019 оны байдлаар 1000 нийт төрөлтөнд ногдох амьгүй төрөлтийн түвшин манай аймагт 3.4 байгаа нь аймгуудын дунджаас 1.0 пунктээр, улсын дунджаас 1.8 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Манай аймгийн 2019 оны амьгүй төрөлтийн түвшинг 2010 онтой харьцуулахад 6.3 пунктээр буюу 2.9 дахин буурсан үзүүлэлттэй байна.


Зураг3.6. 2 . 1 000 нийт төрөлтөнд амьгүй төрөлтийн түвшин, сумаар, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Баруунбаян-Улаан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бат-өлзий	33.3	22.0	26.3	0.0	0.0	11.8	15.2	15.2	0.0	0.0
Баянгол	31.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	111.1	0.0	0.0	0.0
Баян-өндөр	43.5	0.0	0.0	0.0	0.0	166.7	0.0	125.0	333.3	0.0
Богд	55.6	0.0	39.2	0.0	21.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бүрд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гучин-ус	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Есөнзүйл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Зүүнбаян-Улаан	0.0	33.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нарийнтээл	25.0	21.7	0.0	47.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Өлзийт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	90.9	0.0	0.0	0.0
Сант	0.0	0.0	0.0	0.0	0.0	37.0	0.0	0.0	0.0	0.0
Тарагт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Төгрөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Уянга	40.0	0.0	8.0	9.3	0.0	27.3	24.7	0.0	12.3	0.0
Хайрхандулаан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хархорин	10.7	4.0	3.8	3.5	7.3	0.0	7.0	0.0	3.9	6.7
Хужирт	0.0	20.6	11.8	10.8	0.0	0.0	44.8	0.0	11.2	0.0
БОЭТөв	5.4	9.8	4.0	7.3	6.2	4.6	2.6	4.5	4.5	3.4
Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	200.0	0.0
Аймгийн дундаж	9.7	9.1	5.4	6.4	5.4	5.4	5.6	4.1	5.4	3.4

2019 оны амьгүй төрөлтийг төрсөн эмнэлгээр авч үзвэл Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт бүртгэгдэж, сумын эрүүл мэндийн төвүүдэд бүртгэгдээгүй бол өмнөх жилүүдэд сумын эрүүл мэндийн төвүүдэд жил бүр бүртгэгдэж байсан байна.

Зураг3.6.3.Перинаталь эндэгдэл, 1 000 нийт төрөлтөд, улс, аймгаар, 2010-2019 он




2019 оны байдлаар 1000 нийт төрөлтөнд ногдох перинаталь эндэгдлийн түвшин манай аймагт 9.6 байгаа нь аймгуудын дунджаас 1.0 пунктээр, улсын дунджаас 1.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Манай аймгийн 2019 оны амьгүй төрөлтийн түвшинг 2010 онтой харьцуулахад 9.8 пунктээр буюу 2.0 дахин буурсан үзүүлэлттэй байна.

3.7.ҮР ХӨНДӨЛТ


Монгол Улс 1989 онд үр хөндөлтийг хуулиар хүлээн зөвшөөрсөн улсуудын эгнээнд багтсан юм. Ихэнхи эмэгтэйчүүд хүсээгүй үедээ жирэмслэсэнээс үр хөндүүлдэг. Хөгжиж буй орнуудад хүсээгүй жирэмслэлтийн 84.0 хувийг орчин үеийн ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээтэй эмэгтэйчүүд эзэлдэг. Иймд үр хөндөлтийн хувь хэмжээ нь гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүдийн үр ашгийг харуулах чухал үзүүлэлт болдог. Үр хөндөлтийн харьцаа нь үр хөндөлтийн тоог тухайн хугацаан дахь амьд төрөлтийн тоонд харьцуулан 1000 амьд төрөлтөд ногдохоор илэрхийлдэг үзүүлэлт юм.

Зураг3.7.1. 1 000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн түвшин, 2010-2019 он




Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар үр хөндөлтийн түвшин 64.1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.8 пунктэр бага, улсын дунджаас 133.9 пунктээр тус тус бага үзүүлэлттэй байна.

Зураг3.7. 2. Төрөх насны 15-49 насны 1 000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин,2010-2019 он



Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 15-49 насны эмэгтэйчүүдийн үр хөндөлтийн түвшин 5.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктэр нэмэгдэж, улсын дунджаас 13.2 пунктээр бага түвшинд байна.


Зураг3.7. 3. Үр хөндөлтөнд 20 хүртэлх насныхны эзлэх хувь, 2010-2019 он




Үр хөндөлтөнд өсвөр насны охидын үр хөндөлтийн эзлэх хувь 2019 оны байдлаар 8.4 байгаа нь өмнөх оноос 2.9 пунктээр, аймгийн сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 0.8 пунктээр тус тус бага үзүүлэлттэй байна. 2019 оны улс, аймгуудын дундажтай харьцуулбал улсын

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн үр хөндөлтөөс 35-аас дээш насныхны эзлэх хувь 31.7 байгаа нь өмнөх оноос 3.7 пунктээр, 10 жилийн дунджаас 3.3 пунктээр, 2019 оны улсын дунджаас 0.4 пунктээр тус тус өндөр үзүүлэлттэй байна.

Зураг3.7. 4. Үр хөндөлтөнд 35-аас дээш насныхны эзлэх хувь, 2010-2019 он




Зураг3.7. 5. Хожуу үр хөндөлт, 1 000 амьд төрөлтөнд, 2010-2019 он




Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 1 000 амьд төрөлтөнд ногдох хожуу үр хөндөлт 3.1 байгаа нь өмнөх оноос 5.6 пунктээр, аймгийн 10 жилийн дунджаас 3.6 пунктээр, 2019 оны улсын дунджаас 0.2 пунктээр, аймгуудын дунджаас 5.6 пунктээр тус тус бага үзүүлэлттэй байна.

Зураг3.7. 6.Өвөрхангай аймагт бүртгэгдсэн үр хөндөлт, насны ангиллаар, 2010-2019 он



2019 оны байдлаар үр хөндөлтийн 167 тохиолдол бүртгэгдснийг насны ангиллаар авч үзвэл 20 хүртэлх насныхан 8.4 хувийг эзэлж 10 жилийн дунджаас 1.0 пунктээр, 20-24 насныхан 15.6 хувийг эзэлж 10 жилийн дунджаас 1.2 пунктээр, 25-29 насныхан 18.6 хувийг эзэлж 10 жилийн дунджаас 6.9 пунктээр тус тус бага байгаа бол 30-34 насныхан 25.7 хувийг эзэлж 10 жилийн дунджаас 3.8 пунктээр, 35-39 насныхан 18 хувийг эзэлж 10 жилийн дунджаас 2.5 пунктээр, 40-44 насныхан 12.6 хувийг эзэлж 3 пунктээр тус тус нэмэгдэж, 45-49 насныхан 1.2 хувийг эзэлж 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг3.7.7. Өвөрхангай аймагт бүртгэгдсэн үр хөндөлт, эмнэлгийн төрлөөр, 2010-2019 он



2010-2014 онуудад 3546 үр хөндөлт бүртгэгдснээс 69.1 хувь нь хувийн хэвшлийн эмнэлэгт хийгдэж дийлэнх хувийг эзэлж байгаа бол 2015-2019 онуудад 1157 үр хөндөлт бүртгэгдснээс 54.7 хувь нь БОЭТ-д хийгдсэн байна.


3.8.ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГЫН ХЭРЭГЛЭЭ /ЖСАХ/

Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийг зөв зохистой хэрэглэх нь хэт эрт, хожуу жирэмслэхээс сэргийлэх, хэт ойрхон төрөхгүй, төрөлт хоорондын зайг төлөвлөх, нийт хүүхдийн тоог хязгаарлах зэрэг боломжийг олгодог учир эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндэд нэн чухал юм. ЖСАХ-ийг дотор нь орчин үеийн болон уламжлалт гэж ангилдаг ба орчин үеийн аргад умайн гуурсан хоолой эрэгтэй үрийн суваг боох, ерөндөг, тариа, суулгац, эм, бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг болон яаралтай ууж хамгаалах эмийг уух аргууд хамаардаг.

Өвөрхангай аймагт 2019 оны байдлаар жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээг 19991 эмэгтэй хэрэглэсэн бөгөөд төрлөөр нь авч үзэхэд бэлгэвч 27.9 (улсын дундаж 29.8), ерөндөг 34.3 (улсын дундаж 26.4), бэлдмэл /эм/ 20.5 (улсын дундаж 22.4), тариа 9.2 (улсын дундаж 7.3), бусад 3.1 (улсын дундаж 9.0), суулгац/норплант/ 2.2 (улсын дундаж 2.9), стерилизаци 2.8 (улсын дундаж 1.9) хувийг тус тус эзэлж байна.

2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн 48.1 хувь нь ЖСАХ (орчин үеийн эсвэл уламжлалт арга) хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан байна. Мөн гэрлэсэн, эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд гэр бүл төлөвлөхдөө ЖСАХ-ийн орчин үеийн арга хэрэгслийг 15-49 насны эмэгтэйчүүдийн 63.9 хувь нь хэрэглэдэг гэсэн судалгааны үр дүнд дурьджээ.


Зураг3.8.1. ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо, ЖСАХ-ийн төрлөөр, Өвөрхангай, 2015-2019 он



3.9.ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ ЭРҮҮЛ МЭНД


Өвөрхангай аймагт 2019 оны жилийн эцсийн байдлаар 45397 хүүхэд, өсвөр насныхан байгаа бөгөөд нийт хүн амын 39.2 хувийг эзэлж улсын дунджаас 0.9 пунктээр их байна. Үүнээс 1 хүртэлх насны хүүхэд 5.7 хувь, 1-4 насныхан 23.6 хувь, 5-9 насны 27.5 хувь, 10-14 насны 22.9 хувь, 15-19 насныхан 20.3 хувийг тус тус эзэлж байна.

Зураг3.9.1.Хүүхдийн тоо, Өвөрхангай аймаг, 2010,2019 он



Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 0-19 насны нийт 45397 хүүхэд, өсвөр насныхан байгаа нь 2010 онтой харьцуулахад 1.2 хувиар өссөн байна.

Зураг3.9.2. Нийт хүн амд хүүхдийн эзлэх хувь 2010, 2019 он



Аймгийн хэмжээнд 0-1 хүртэлх насны хүүхэд нийт хүн амын 2.2 хувийг эзэлж байгаа нь улсын дундажтай харьцуулахад ижил түвшинд, 1-4 настай хүүхэд 9.2 хувийг эзэлж, улсын дунджаас 0.3 пунктээр их, 5-9 насны хүүхэд 10.8 хувийг эзэлж, улсын дунджаас 0.5 пунктээр бага, 10-14 насны өсвөр үеийнхэн 9.0 хувийг эзэлж, улсын дунджаас 0.5 пунктээр их, 15-19 насны өсвөр үеийнхэн 8.0 хувийг эзэлж, 1.2 пунктээр их үзүүлэлттэй байна.

3.10 . ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Манай аймгийн хувьд 2019 оны байдлаар нийт 285 их эмч ажиллаж байгаагаас хүүхдийн эмч 20 байгаа ба үүнээс нярай хүүхдийн эмч 2, хүүхдийн мэс заслын эмч 1, хүүхдийн мэдээгүйжүүлгийн эмч 8, хүүхдийн эрчимт эмчилгээний эмч 2 байна. Хүүхдийн эмчийн тоо жил дараалан нэмэгдэж байгаа хэдий ч нэг эмчид ногдох хүүхдийн тоо өндөр хэвээр байна.

3.11.ИДЭВХТЭЙ ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэг хүртэлх насны хүүхэд бүрийн идэвхтэй хяналтад хамруулж, тусламж үйлчилгээг байнгын үзүүлж байхыг заасан байдаг.

Эрүүл мэндийн статистик мэдээгээр 2019 онд тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад хамрагдсан 56312 хүүхдүүдийн 0.3 хувь нь туранхай буюу улсын дундажтай ижил түвшинд, 0.1 хувь нь тураалтай буюу улсын дунджаас 0.1 пунктээр бага, 0.6 хувь нь өсөлтийн хоцрогдолтой буюу улсын дунджаас 0.3 пунктээр их үзүүлэлттэй байсан байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд 2012-2025 онуудад улсын хэмжээнд 5 хүртэлх насны, өсөлт хоцрогдолтой хүүхдийн хувийг 40 хувиар, туранхай хүүхдийн хувийг 5-аас бага болтол бууруулж, илүүдэл жинтэй хүүхдийн хувийг нэмэгдүүлэхгүй байх зорилт дэвшүүлсэн.

Хоол тэжээлийн дутлын тархалтыг бууруулснаар урьдчилан сэргийлэх боломжтой нярай, хүүхдийн эндэгдлийг тэглэх зэрэг дэлхий нийтээр дэвшүүлсэн бусад олон чухал зорилтын хэрэгжилтэд хувь нэмэр оруулах боломжтой.

Биеийн жин, насны харьцаа нь 5 хүртэлх насны хүүхдийн голч үзүүлэлтээс 2 стандарт хазайлтаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн тураалтай, харин 3 СХ-аас доогуур байвал хүнд хэлбэрийн тураалтай гэж үнэлдэг. Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь хүүхдийн өсөлтийг илэрхийлэх хэмжигдэхүүн юм. Хоол тэжээлийн архаг дуталд хүүхэд өртвөл хүүхдийн өсөлт удааширч үеийнхнээсээ намхан болдог.

Өсөлт хоцролт нь хүүхэд насандаа байвал зохих өндөрт хүрэхгүй буюу намхан байгааг харуулах бөгөөд энэ нь хоол тэжээлийн архаг дутлын илэрхийлэл болдог. Өсөлт хоцролт нь урт удаан хугацааны туршид хангалтгүй хооллож байсан, архаг өвчтэй болсон, олон дахин өвчилсөн зэргээс шалтгаалж үүсдэг.

Биеийн жинг өндөрт харьцуулсан үзүүлэлт нь туранхай болон илүүдэл жинтэй байдлыг илэрхийлдэг. 5 хүртэлх насны жишиг хүн амын голчоос 2 СХ доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн туранхай, харин 3 СХ доогуур байвал хүнд хэлбэрийн туранхай гэж үнэлдэг. Хүүхэд туранхай байх нь хоол тэжээлийн хурц дутлын илэрхийлэл болно. Энэ нь ихэвчлэн улирлын байдлаас шалтгаалсан хоол хүнсний хомсдол, өвчлөлтэй холбоотой. Харин жишиг хүн амын 2 СХ дээгүүр байвал дунд болон хүнд зэргийн илүүдэл жинтэй хүүхдийг илэрхийлдэг.

3.12. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Хүн амын эрүүл мэндийн зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болох төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэг, сэргээн засах, оролцоо, боловсролын үйлчилгээнд аль болох эрт хамруулах нь чухал юм.

2019 оны байдлаар улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1 хүртэлх насны 14, тав хүртэлх насны 85 хүүхэд байгаа нийт хүүхдийн 1 орчим эзэлж байгаа нь хэдий бага мэт боловч хүүхдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулж, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлж эмчлэх нь өрх, сумын эрүүл мэндийн төвийн гол үйл ажиллагааны нэг юм.

Аймгийн хэмжээнд 5 хүртэлх насны нийт хүүхдийн 0.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь улсын дунджаас 0.6 пунктээр бага, 5-9 насны хүүхдийн 1.0 хувь байгаа нь улсын дунджаас 0.1 пунктээр их, 10- 14 насны хүүхдийн 1.4 хувь байгаа нь улсын дунджаас 0.3 пунктээр их, 15-19 насныхны 1.7 хувь нь ямар нэгэн үйл ажиллагааны бэрхшээлтэй байгаа нь улсын дунджаас 0.5 пунктээр бага байна.

Зураг3.13.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхны тоо, тухайн насны 1 000 хүүхдэд эзлэх хувь, төрлөөр, 2015-2019 он

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Тайлант он	0-5 хүртэлх			5-9 нас			10-14 нас			15-19 нас		
		Тоо	Хувь	Тухайн насны 1000 хүүхдэд	Тоо	Хувь	Тухайн насны 1000 хүүхдэд	Тоо	Хувь	Тухайн насны 1000 хүүхдэд	Тоо	Хувь	Тухайн насны 1000 хүүхдэд
Харааны	2015	10	10.0	0.8	16	9.9	1.5	19	11.0	2.0	30	14.6	2.8
	2016	6	6.3	0.5	28	18.1	2.4	24	15.0	2.6	26	12.9	2.4
	2017	8	8.4	0.6	30	20.5	2.5	25	17.0	2.7	30	15.5	2.9
	2018	11	10.2	0.8	25	18.1	2.0	25	15.2	2.6	34	17.1	3.4
	2019	10	11.8	0.7	20	16.5	1.6	22	15.7	2.2	39	23.5	4.1
Сонсголын	2015	9	9.0	0.7	14	8.6	1.3	15	8.7	1.6	11	5.3	1.0
	2016	7	7.4	0.5	10	6.5	0.9	14	8.8	1.5	13	6.4	1.2
	2017	6	6.3	0.4	10	6.8	0.8	15	10.2	1.6	8	4.1	0.8
	2018	6	5.6	0.4	8	5.8	0.7	17	10.3	1.8	10	5.0	1.0
	2019	4	4.7	0.3	5	4.1	0.4	14	10.0	1.4	15	9.0	1.6
Ярианы	2015	4	4.0	0.3	10	6.2	0.9	22	12.7	2.3	23	11.2	2.1
	2016	7	7.4	0.5	10	6.5	0.9	17	10.6	1.9	22	10.9	2.1
	2017	5	5.3	0.4	13	8.9	1.1	14	9.5	1.5	19	9.8	1.8
	2018	6	5.6	0.4	12	8.7	1.0	14	8.5	1.5	17	8.5	1.7
	2019	6	7.1	0.4	11	9.1	0.9	13	9.3	1.3	11	6.6	1.2
Хөдөлгөөний	2015	23	23.0	1.8	40	24.7	3.7	41	23.7	4.4	39	18.9	3.6
	2016	25	26.3	1.9	25	16.1	2.2	28	17.5	3.1	36	17.8	3.4
	2017	25	26.3	1.9	24	16.4	2.0	28	19.0	3.1	32	16.5	3.1
	2018	27	25.0	2.0	29	21.0	2.4	30	18.2	3.1	30	15.1	3.0
	2019	15	17.6	1.1	27	22.3	2.2	27	19.3	2.7	36	21.7	3.8
Сэтгэцийн	2015	22	22.0	1.7	30	18.5	2.8	32	18.5	3.4	39	18.9	3.6

	2016	14	14.7	1.1	30	19.4	2.6	36	22.5	4.0	48	23.8	4.5
	2017	15	15.8	1.1	32	21.9	2.7	38	25.9	4.1	46	23.7	4.4
	2018	19	17.6	1.4	27	19.6	2.2	42	25.5	4.4	49	24.6	5.0
	2019	15	17.6	1.1	23	19.0	1.8	30	21.4	2.9	34	20.5	3.6
Хавсарсан	2015	9	9.0	0.7	20	12.3	1.8	19	11.0	2.0	30	14.6	2.8
	2016	8	8.4	0.6	16	10.3	1.4	18	11.3	2.0	19	9.4	1.8
	2017	10	10.5	0.7	17	11.6	1.4	11	7.5	1.2	19	9.8	1.8
	2018	12	11.1	0.9	18	13.0	1.5	14	8.5	1.5	19	9.5	1.9
	2019	8	9.4	0.6	9	7.4	0.7	10	7.1	1.0	6	3.6	0.6
Бусад	2015	23	23.0	1.8	32	19.8	2.9	25	14.5	2.7	34	16.5	3.1
	2016	28	29.5	2.1	36	23.2	3.1	23	14.4	2.5	38	18.8	3.6
	2017	26	27.4	1.9	20	13.7	1.7	16	10.9	1.7	40	20.6	3.9
	2018	27	25.0	2.0	19	13.8	1.5	23	13.9	2.4	40	20.1	4.1
	2019	27	31.8	2.0	26	21.5	2.1	24	17.1	2.4	25	15.1	2.7
Нийт	2015	100	-	7.8	162	-	14.9	173	-	18.4	206	-	19.0
	2016	95	-	7.2	155	-	13.5	160	-	17.6	202	-	19.0
	2017	95	-	7.1	146	-	12.2	147	-	16.0	194	-	18.8
	2018	108	-	8.0	138	-	11.2	165	-	17.1	199	-	20.2
	2019	85	-	6.3	121	-	9.7	140	-	13.8	166	-	17.7

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 0-19 насны хөгжлийн бэрхшээлтэй 512 хүүхэд бүртгэгдэж өмнөх онтой харьцуулахад 98 тоогоор буюу 16.1 хувиар буурсан байна. 2019 оны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхны тоо, эзлэх хувь, төрлөөр:

- Харааны бэрхшээл - 91 (17.8 хувь)
- Сонсголын бэрхшээл - 38 (7.4 хувь)
- Ярианы бэрхшээл – 41 (8.0 хувь)
- Хөдөлгөөний бэрхшээл – 105 (20.5 хувь)
- Сэтгэцийн – 102 (19.9 хувь)

- Хавсарсан – 33 (6.5 хувь)
- Бусад – 102 (19.9 хувь) тус тус эзэлж байна.


3.13. ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАЛТ

Дархлаажуулалт нь амь насанд аюултай халдварт өвчнийг хянах, устгахад чиглэсэн шалгарсан арга бөгөөд жил бүр 2-3 сая хүний амь насыг авардаг гэсэн тооцоо бий. Энэ нь өртөг зардгал хамгийн багатай эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын нэг бөгөөд хүрэхэд хамгийн хүндрэлтэй, эмзэг бүлгийн хүн амд хүртээмжтэй хүрч чаддаг хамгийн үр дүнтэй хэрэгсэл юм. ДЭМБ-ын Хүүхдийн Дархлаажуулалтын Товлолын талаарх Зөвлөмжид бүх хүүхдийг сүрьеэ, сахуу, татран, хөхүүл ханиад, саа, улаан бурхан, гепатит В, хемофилюс инфлюэнза Б, пневмококийн нян, ротавирус, улаануудын эсрэг зэрэг вакцинд хамруулахыг зөвлөмж болгосон.

2001 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар УИХ дархлаажуулалтын тухай хуулийг баталсан.

Манай Улсад 2005 оноос өмнө хүүхдийг сүрьеэ, сахуу, хөхүүл ханиад, татрангийн гуравт, улаан бурхан, гепатит В-гийн болон улаан бурханы вакцинаар дархлаажуулж байсан. 2005 оноос хойш сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, Хиб-ийн таван вакциныг нэгтгэсэн нэг вакциныг үе шаттайгаар нэвтрүүлж, 2009 оноос улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг нийлсэн нэг вакциныг "Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол"-д шинээр оруулсан. Харин 2011 оноос А вируст гепатитийн эсрэг вакциныг "Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол"-д шинээр оруулсан.

Зураг.3.13. 1. Дархлаажуулалтын хамралтын хувь



Эх үүсвэр: Эрүүл мэндийн үзүүлэлт 2010-2019 он

Аймгийн хэмжээнд нэг хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтыг 2019 оны байдлаар сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулан харахад төрсний дараа 24 цагийн дотор хийдэг сүрьеэгийн эсрэг (БЦЖ) вакцины хамралт 0.2 пунктээр буурсан, халдварт саагийн эсрэг вакциных 0.1 пунктээр нэмэгдсэн, гепатит В-ийн эсрэг вакцины хамралт 0.1 пунктээр буурсан байна. Хүүхдэд 2 сартайгаас эхэлж 3 тун хийдэг тавт вакцины (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатит В, хемофилюс инфлюенз В өвчний эсрэг вакцин) 3 дугаар тунгийн хамралт 0.1 пунктээр, 9 сартай хийдэг УГУ (улаанбурхан, гахайн хавдар, улаануудын хавсарсан вакцин)-ын эсрэг вакцины хамралт 0.1 пунктээр нэмэгдсэн байна. Амьдралын эхний 2-4 сартай нярай хүүхдэд саагийн эсрэг вакцинжуулалтын хамрах хүрээ 98.7% -д, тавт вакцин 99.4%-д тус тус хүрчээ.

Зураг.3.13. 2. Заавал хийх дархлаажуулалтын хамралтын хувь, улс, аймгаар, 2012-2019 он



3.14.ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ ӨВЧЛӨЛ

5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлсээр байна.

Тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөлийн тохиолдол 2019 онд 6708 болж, сүүлийн 5 жилийн дундажаас 1897 (39.5%)-аар, өмнөх оноос 1357 (25.4%)- аар тус тус нэмэгджээ. Тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний түвшин (10000 хүүхдэд ногдох) 2019 онд 4901 болж, улсын дунджаас 1504 пунктээр бага хэдий ч аймгийн сүүлийн 5 жилийн дундажаас 1283-аар, өмнөх оноос 914-өөр тус тус нэмэгджээ.

Хоол боловсруулах тогтолцооны өвчнөөс халдварт бус суулгалт, шүдний цоорол, шүдний дайврын эмгэгүүд тэргүүлж байна. Суулгалт өвчин нь дэлхий даяар 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын зонхилох шалтгаануудын нэг хэвээр байна. Суулгалт өвчний үед хүүхэд их хэмжээний шингэн алдаж, ус, электролитийн дутагдалд орсны улмаас амь нас нь эрсдэж байна.

2019 оны байдлаар харахад хүүхдийн өвчлөлд 1-14 насны хүүхдэд амьсгалын тогтолцооны өвчин, 15-19 насанд хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлж байна.

2019 оны байдлаар харахад хүүхдийн өвчлөл насны бүлэг тус бүрдээ өмнөх онуудаас нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт.3.15.1. Нялхас ба 5 ба хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, тохиолдлын тоогоор, 2015-2019 он

	2015		2016		2017		2018		2019	
	Нялхас	1-5 хүртэлх нас	Нялхас	1-5 хүртэлх нас	Нялхас	1-5 хүртэлх нас	Нялхас	1-5 хүртэлх нас	Нялхас	1-5 хүртэлх нас
Амьсгалын тогтолцооны өвчин	1120	1856	1409	2529	1705	3374	1811	3540	2272	4436
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	229	896	277	887	371	1233	281	1055	495	1395
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	24		22		26		48		89	
Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	26	210	25	145	24	143	29	157	24	123
Халдварт ба шимэгчит зарим өвчин	41	103	332	307	27	274				
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	205	416	282	522	303	579	213	540	360	719
Нүд ба түүний дайвар, Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	261	374	226	409	299	529	316	524	311	587
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	20	91	23	85	12	168	19	144	16	164
Бусад өвчлөл	139	114	145	145	177	200	140	179	143	152
Нийт халдварт бус өвчлөл	2136	4058	2555	4785	3082	6360	2936	6244	3865	7655

Эх үүсвэр: Health-info3 цахим мэдээллийн сан, 2015-2019 он


Хүснэгт.3.15. 2 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

	2015		2016		2017		2018		2019	
	5-9 нас	10-19 нас	5-9 нас	10-19 нас	5-9 нас	10-19 нас	5-9 нас	10-19 нас	5-9 нас	10-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	726	845	1029	944	1335	1154	1254	903	1917	1406
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1571	1839	1352	1634	2030	2140	2267	1948	2537	2270
Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг	20	57	16	82	25	81	14	53	25	39
Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	181	476	118	316	155	321	131	319	134	279
Халдварт ба шимэгчит зарим өвчин	81	149	198	402	166	133				
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	327	748	366	696	419	723	425	826	637	1010
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	305	711	338	544	439	638	480	602	550	701
Мэдрэлийн тогтолцооны өвчин	109	290	66	262	146	399	114	368	158	230
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	82	504	113	499	171	563	194	534	226	644
Бусад өвчлөл	158	389	1387	421	131	552	122	477	152	442
Нийт халдварт бус өвчлөл	3479	5859	4785	5398	4851	6571	5001	6030	6336	7021


3.16. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2019 онд 0-5 хүртэлх насны хүүхдийн 46 тохиолдол бүртгэгдэж сүүлийн 10 жилийн дунджаас 15 тохиолдлоор, нялхсын эндэгдлийн 38 тохиолдол бүртгэгдэж сүүлийн 10 жилийн дунджаас 11 тохиолдлоор, 0-28 хоногтой нярайн эндэгдлийн 22 тохиолдол бүртгэгдэж 10 жилийн дунджаас 7 тохиолдлоор тус тус буурсан байна.

Зураг.16.1. Хүүхдийн эндэгдэл, бодит тоогоор, Өвөрхангай, 2010-2019 он




Зураг.16. 2. Хүүхдийн эндэгдлийн түвшин, Өвөрхангай аймаг, 2010-2019 он



Аймгийн хэмжээнд 2019 онд 1 000 амьд төрөлтөнд ногдох 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 9.8 болж , нялхсын эндэгдлийн түвшин 8.3, нярайн эндэгдлийн түвшин 5.4 байна.

Зураг.16. 3. Нялхсын эндэгдэл, гэрийн эндэгдэл, 2010-2019 он




Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ

Аймгийн хэмжээнд 2019 онд эндсэн нялхсаас 30.1 хувь нь гэртээ эндсэн нь өмнөх оноос 5.1 пунктээр, сүүлийн 10 жилийн дунджаас 10.5 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3.17.ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ШАЛТГААН

Нярайн эндэгдлийн эндэгдлийн шалтгаанаар авч үзвэл: Нярайн тархины хямрал 2019 онд (47.1%), 2017 онд (46.7%), 2016 онд (82.4%), 2015 онд (57.1%), 2014 онд (66.7%) эзэлж, нярайн амьсгал гачаал 2018 онд (50.0%) -г тус тус эзэлж нярай хүүхдийн нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.

Зураг.3.17. 1. Нярайн үеийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, Өвөрхангай, тохиолдлын тоогоор 2014-2019 он




Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ

Зураг.3.17. 2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх 6 шалтгаан, тохиолдлын тоогоор

	2014	2015	2016	2017	2018	2019
Нярайн амьсгал гачаал(P22)	10	8	8	7	7	5
Үүсгэгч тодорхойгүй пневмони (J18)	7	9	9	6	4	8
Нярайн тархины бусад хямрал(P91)	3	3	3	6	4	8
Амьсгал боох аюултай бусад осол (W75-W84)	3	5	5	5	5	1
Дутуу тээлт болон ураг бага жинтэй төрснөөс улбаалсан өөр бүлэгт ангилаагүй эмгэг (P07)	1	2	2	2	1	1
Зам тээврийн осол (V00-V99)	0	2	2	3	0	1

Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ


Зураг.3.17. 3. Нялхсын эндэгдэлд амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант эндэгдэл, 2010-2019 он



Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ

Амьсгалын тогтолцооны өвчлөлийн шалтгаант нас баралт 2019 онд нялхсын эндэгдлийн 18.4 хувийг эзэлж байсан бол, хамгийн ихдээ 2010 онд 29.5 хувийг, хамгийн багадаа 2017 онд 10.3 хувийг тус тус эзэлж байсан байна.


Зураг.3.17. 4. 5-9 насны хүүхдийн эндэгдлийн тоо, тухайн насны 1000 хүүхдэд, 2010-2019 он



Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ

2019 оны байдлаар манай аймагт 5-9 насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж тухайн насны 1000 хүүхдэд ногдох эндэгдлийн түвшин 0.4 байгаа нь улсын дунджаас 0.1 пунктээр өндөр байна. Аймагийн үзүүлэлтийг өмнөх он болон сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулбал 0.1 пунктээр их байна.


Зураг.3.17. 5. 10-14 насны хүүхдийн эндэгдлийн тоо, тухайн насны 1000 хүүхдэд, 2010-2019 он



Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ

2019 оны байдлаар манай аймагт 10-14 насны хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж тухайн насны 1000 хүүхдэд ногдох эндэгдлийн түвшин 0.2 байгаа нь улсын дунджаас 0.1 пунктээр бага байна. Аймагийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 0.1 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулбал 0.2 пунктээр тус тус буурсан байна.

Зураг.3.17. 6. 15-19 насны хүүхдийн эндэгдлийн тоо, тухайн насны 1000 хүүхдэд, 2010-2019 он



Эх үүсвэр: Health-info-3 ЭММ-ийн программ

2019 оны байдлаар манай аймагт 15-19 насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж тухайн насны 1000 хүүхдэд ногдох эндэгдлийн түвшин 0.4 байгаа нь улсын дунджаас 0.2 пунктээр бага байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 0.5 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулбал 0.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн онцгой ивээлд нэгдсэн зохицуулалттай байж, тусламж үйлчилгээг үзүүлэхдээ төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг харилцан ашигтай, шударга, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тэгш хүртээмжтэй байхад чиглэнэ.

Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний албан ёсны статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандарттай харьцуулан дүгнэхийг хичээсэн.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн онцгой ивээлд нэгдсэн зохицуулалттай байж, тусламж үйлчилгээг үзүүлэхдээ төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг харилцан ашигтай, шударга, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тэгш хүртээмжтэй байхад чиглэнэ.

Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний албан ёсны статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандарттай харьцуулан дүгнэхийг хичээсэн бөгөөд манай улс нь эмнэлгийн тусламж үйлчилгээний 3 шатлалт тогтолцоотой бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд баримтлах зарчим нь үйлчилгээг хүн бүрт жигд, хүртээмжтэй чанартай үзүүлэх явдал юм.

Өвөрхангай аймгийн хүн амд Өрхийн эрүүл мэндийн төв, Сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сувилал, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Хувийн ортой эмнэлэг, Хувийн клиник эмнэлгүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

2019 оны байдлаар Өвөрхангай аймгийн хэмжээнд нийт 64 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба тусгай мэргэжлийн төв 1, бүсийн оношлогоо эмчилгээний төв 1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 1, сумын эрүүл мэндийн төв 17, өрхийн эрүүл мэндийн төв 5, хувийн ортой эмнэлэг 6, хувийн клиник 33 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна


Хүснэгт.4.1. Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2019 он

Эрүүл мэндийн байгууллагууд		2019 он
Багийн эмчийн салбар		2
Өрхийн эрүүл мэндийн төв		5
Сумын эрүүл мэндийн төв	А зэрэглэл	4
	Б зэрэглэл	
	В зэрэглэл	10
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг		1
Бүсийн оношлогоо эмчилгээний төв		1

Тусгай мэргэжлийн төв	1
Клиник /хувийн/	27
Ортой хувийн эмнэлэг	6
Сувилал	5
Эрүүл мэндийн газар (аймаг, нийслэл)	1
Эм ханган нийлүүлэх байгууллага	2
Эмийн сан	51
Бусад	4
Нийт	120

2019 онд аймгийн хэмжээнд 856 эмнэлгийн ор ашигласан бөгөөд төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад 721 ор ашиглаж нийт орны 84.2 хувийг, хувийн хэвшлийн эмнэлэгт 135 ор ашиглаж 15.8 хувийг тус тус эзэлж байна. 2010-2019 оны хооронд аймгийн хэмжээнд эмнэлгийн орны тоо 34.6 хувиар нэмэгдсэн хэдий ч улсын дундажтай харьцуулахад 8.4 пунктээр бага байна.

Зураг4.1.1 Эрүүл мэндийн байгууллагын орны тоо, 2010-2019 он



2019 онд аймгийн хэмжээнд нийт 856 ор ашиглаж 10 000 хүн амд 73.4 ор ноогдож байгаа нь өмнөх оноос 23 ороор буюу 10 000 хүн амд ногдох ор 1.4 пунктээр нэмэгдсэн байна. Аймгийн үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад дэлгэсэн орны тоо 220-оор буюу 10 000 хүн амд ногдох ор 16.6 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт.4.2. Эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилчдын тоо, 2019 оны байдлаар

Эрүүл мэндийн байгууллагууд	Их эмч	Сувилагч	Эм зүйч	Эх баригч	Нийт ажилчид
Багийн эмчийн салбар	3	9	0	1	23
Өрхийн эрүүл мэндийн төв	20	20	0	1	59

Тарагт	2	1	2	2	2	3	3	2	3	2
Төгрөг	2	2	3	3	3	2	3	2	3	1
Уянга	5	4	7	7	7	9	7	6	8	10
Хайрхандулаан	2	2	2	3	3	3	3	3	2	3
Хархорин	14	16	18	21	0	22	26	27	27	25
Хужирт	9	9	8	6	6	6	7	8	6	7

Эх үүсвэр: Цахим мэдээллийн сан-www. 1212.mn

Хүснэгт4.1.2.Их эмч, мэргэжлийн төрлөөр,2015-2019 он

Засаг захиргааны нэгж	2015	2016	2017	2018	2019
Их эмч -Бүгд	248	255	258	265	285
Ерөнхий мэргэжлийн	65	76	59	69	78
Үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн	137	126	139	139	141
Дотрын	19	18	20	22	26
Хүүхдийн	29	26	21	21	24
Мэс заслын	12	12	12	10	7
Гэмтлийн	2	3	5	5	6
Сэхээн амьдруулахын	0	1	1	1	2
Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний	6	4	4	8	12
Мэдрэлийн	6	6	8	10	7
Эх барих эмэгтэйчүүдийн	20	21	20	20	21
Хавдрын	1	1	3	1	1
Сэтгэцийн	2	2	2	2	2
Нүдний	3	3	3	3	4
Чих хамар хоолойн	1	1	2	3	3
Арьс, харшлын	3	3	3	3	3
Халдвартын	4	5	10	9	9
Сүрьеэгийн	2	1	2	2	2
ДОХ/БЗДХ-ын/	1	1	2	2	1
Сэргээн засахын	3	1	0	0	1
Хөнгөвчлөхийн	2	2	2	1	1
Настны	1	1	1	1	1
Эмгэг судлалын	3	1	1	1	1
Дүрс оношилгооны	6	7	10	6	4
Лабораторын	7	4	5	4	3
Уламжлалт анагаахын	7	4	6	8	10
Нүүр амны	29	34	41	37	40
Бусад	17	19	19	20	20

Эх үүсвэр: Цахим мэдээллийн сан-www. 1212.mn

4.1. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ


Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь бүх иргэдэд үнэ төлбөргүй байдаг бөгөөд Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн орлогоос санхүүждэг.

Манай аймгийн өрх, сумын эрүүл мэндийн төвүүд нь харъяаллын хүн амд чиг үүргийн дагуу тав хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалт, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, эх, хүүхдийн гэрийн эргэлт зэрэг 8 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Монгол орны цаг уурын эрс тэс уур амьсгалын улмаас өвөл, хаврын улиралд амьсгалын замын өвчлөл нэмэгддэг нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь харъяаллын хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, тодруулбал, амбулаторийн үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, зарим лабораторийн шинжилгээ, дархлаажуулалт, гэрийн үзлэг, эмчилгээг хийж байна.


2019 оны байдлаар 4 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Уянсэтгэл өрхийн эмнэлэг нь 9 511 хүн амд, Түшигдөлгөөн өрхийн эмнэлэг нь 10 533 хүн амд, Нарны-дөш өрхийн эмнэлэг нь 12 847 хүн амд, Энэрэл-Хархорин өрхийн эмнэлэг нь 8 472 хүн амд тус тус эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2019 онд аймгийн хэмжээнд нийт 1525 эрүүл мэндийн ажилчид байгаагаас 59 ажилчин өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж 3.9 хувийг эзэлж байна.

Зураг.4.1. 1.Өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгийн тоо (2018-2019 он)



2019 оны байдлаар Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 92744 үзлэг хийгдсэнээс 32.2 хувь нь Уянсэтгэл ӨЭМТөвд, 26.3 хувь нь Түшигдөлгөөн ӨЭМТөвд, 22.0 хувь нь Нарны дөш ӨЭМТөвд, 19.4 хувь нь Хархорин сум дахь Энэрэл-Хархорин ӨЭМТ-д тус тус үйлчлүүлсэн байна.

Зураг.4.1. 2.Өрхийн эрүүл мэндийн төвийн үзлэг, үзлэгийн төрлөөр (2018-2019 он)




2019 онд Өрхийн эмнэлгүүдэд хийгдсэн нийт үзлэгийн 32.3 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, 24.6 хувь нь амбулаторын үзлэг, 27.6 хувь нь диспансерийн хяналтын үзлэг, 15.5 хувь нь гэрийн үзлэг байна.

Хүснэгт.4.1.1.Жирэмсний эрт үеийн хяналтын хувь

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Уянсэтгэл	76.7	81.4	74.1	77	78.4	81.4	76.2	82.8	80.2	89.1
Түшигдөлгөөн	80.9	87.5	78.1	87.9	84.7	85.2	84.6	91.4	88.3	91.9
Нарны дөш	78.3	81.4	80.1	76.1	79.2	82.8	81.2	80.8	85.2	90.1
Энэрэлхархорин	84.6	90.4	89.4	92.2	90.4	89.3	85.9	90.6	88.5	85.4
Өрхийн дундаж-Өв	80.1	85.2	80.4	83.3	83.2	84.7	82.0	86.4	85.6	89.1
Аймгийн дундаж	84.1	86.1	84.3	86.5	86.0	86.4	85.5	88.7	87.3	90.6
Өрхийн дундаж-улс	83.4	85.4	86.7	86.7	85.1	83.6	83.1	85.5	86.9	86.1

2019 оны байдлаар аймгийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн жирэмсний эрт үеийн хяналтын хувь 90.6 байгаа нь улсын дунджаас 4.5 пунктээр, аймгийн сүүлийн 10 жилийн дунджаас 4.0 пунктээр, өмнөх оноос 3.3 пунктээр тус тус өндөр үзүүлэлттэй байна.

Зураг.4.1. 1. Өрхийн жирэмсний эрт үеийн хяналт, улс, аймаг /нийт, өрх/, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн нийт өрхийн эрүүл мэндийн төвүүдийн жирэмсний эрт үеийн хяналтын дундаж хувь 89.1 байгаа нь аймгийн дунджаас 1.5 пунктээр их, улсын хэмжээний нийт өрхийн дунджаас 3.0 пунктээр их байна.

Өрхийн эрүүл мэндийн төвд их эмч 20, сувилагч 20 болон нийт 59 эмч, эмнэлгийн ажиллагчид хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад 1 800- 2 000 хүн тутамд 1 их эмч ажиллана гэж заасан хэдий ч 2019 оны байдлаар аймгийн хэмжээнд хэмжээнд 1 өрхийн эмчид 2036 хүн ногдож байна.

4.1.1. Нэг сувилагчид ноогдох хүн амын тоо



Зураг 4.1.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгийн тоо (2018-2019 он)



Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд аймагт нэг их эмчид ногдох хүний тоо стандартад заасан хэмжээнд байгаа бусад аймгуудад Стандартын хэмжээнээс өндөр байна. 2019 онд өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд жилд 92744 үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2-3 удаа өрхийн эрүүл мэндийн төвд хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь өмнөх оноос 0.6 хувиар нэмэгдсэн байна. “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30 хувиас доошгүй байна гэж заасан хэдий ч 2019 оны байдлаар 15.5 байгаа нь улсын дунджаас 11.9 пунктээр бага байна.

4.2. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БОЛОН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно. Сум дундын эмнэлэг нь хүн амын суурьшил, нягтралаас хамааран харьяалалын болон зэргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. 2013 онд батлагдсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-аар сумын эрүүл мэндийн төвүүд нь аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилна. Нэгдүгээр зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ийн дотор үйлчлэх хүрээний хүн ам 3000 хүртэл, хоёрдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50-99 км-ийн дотор болон 1-2 цаг хүртэлх хугацаанд зорчих сумын эрүүл мэндийн төв, гуравдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 100км-ээс алс, сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэг хамаарна гэж заасан. Гэвч сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ээс дотогш боловч үйлчлэх хүрээний хүн амын тоо 3 000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан бол хоёрдугаар зэрэглэлд, 100 км-ээс дотогш боловч хүн амын тоо 8000-аас дээш бол гуравдугаар зэрэглэлд хамааруулна гэж заасны дагуу доорх хүснэгтэд сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг тогтоосон.


Зураг.4.2. 1. Сумын эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэг, 2010-2019 он, Өвөрхангай аймаг



4.3 БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ХАРХОРИН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ


Нэгдсэн эмнэлэг нь хүн амд 7-оос доошгүй чиглэл /дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно.

Зураг.4.3. 1. Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо, 2010-2019 он




2019 оны байдлаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт 153422 үзлэг хийгдэж нийт үзлэгийн 41.7 хувийг эзэлж байсан бол 2018 онд нийт үзлэгийн 36.5 хувийг эзэлж байсан байна.

Зураг.4.3. 2. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, 2010-2019 он




2019 оны байдлаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үзлэгийн 21.3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.8 пунктээр нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.7 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт хийгдсэн үзлэгийн 13.2 хувийг хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байгаа нь өмнөх оноос 2.9 пунктээр, сүүлийн 10 жилийн дунджаас 4.9 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.4.3. 3. БОЭТ, Нэгдсэн эмнэлгийн стационарын түслэмж үйлчилгээний үзүүлэлт/ хэвтэн эмчлүүлэгч ийн тоо/, 2010-2019 он




2019 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 10687 хүн хэвтэн эмчлүүлж нийт стационараар үйлчлүүлэгчдийн 42.7 хувийг, ХХНЭ-т хэвтэж эмчлүүлсэн иргэд 10.7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг.4.3. 4. Хоног болоогүй нас баралтын хувь, 2010-2019 он



2019 оны байдлаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нас барсан тохиолдлын 21.9 хувь нь хоног болоогүй нас барсан ба өмнөх онтой харьцуулахад 4.3 пунктээр нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 3.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.4.3. 5. Хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, 2010-2019 он




2019 оны байдлаар Хувийн ортой 6 эмнэлэг үйл ажиллагаа явуулж нийт 4031 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна. Хэвтэн эмчлүүлэгчдийг өмнөх онтой харьцуулахад 254-өөр буурч, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 717-оор нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн салбарт 2019 онд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд болон бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид нийт 1525 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5.3 хувиар өссөн байна.


Зураг 5.1.1. Эрүүл мэндийн ажилчдын тоо




Нийт ажиллагчдаас 96.8 хувь нь эрүүл мэндийн салбарын, 3.2 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна. 2019 оны байдлаар эрүүл мэндийн салбарын байгууллагын ажиллагчдын 26,9 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд,

17,5 хувь нь сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвд, 7,5 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 14,2 хувь нь сувиллуудад ажиллаж байна.

Зураг.5. 2. Үйл ажиллагаа явуулж эрүүл мэндийн байгууллагууд, эзлэх хувиар, 2019 он




Зураг.5. 3. Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц, хүчин чадал, 2019 он



Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 120 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Жилээс жилд халаалт, усан хангамж, агааржуулалт зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсэн эмнэлгийн тоо нэмэгдэж байна.


Зураг.5. 4. Эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадлын үзүүлэлт, 2019 он



БҮЛЭГ VI. ХАЛДВАРТ ӨВЧИН


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор халдварт өвчнийг тандах, сэргийлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг уян хатан, чанартай, хүртээмжтэй, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэхэд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар халдварт өвчний тархалтыг бууруулах зорилгоор “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг баталсан. “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлыг (10 000 хүн амд) 2020 он гэхэд 14.4 болгох зорилт тавьсан бөгөөд 2019 онд улсын хэмжээнд 11.2 байгаа бол манай аймаг 5.0 байна. Гепатит А вирусийн цочмог халдварт өвчний түвшин (10 000 хүн амд ногдох-г 2020 онд улсын хэмжээнд 8 болгох зорилт 2019 онд улсын үзүүлэлт 0.5 байгаа бол манай аймаг 0.0 байна. Гепатит В вирусийн цочмог халдварын өвчлөлийн түвшинг улсын хэмжээнд 2020 онд 1.3 болгох зорилт улсын хэмжээнд 2019 онд 0.7 байгаа бол манай аймагт 0.6 байна.

Зураг.6. 1. Нийт халдварт өвчин, улс,аймгаар, 10 000 хүн амд ногдох өвчлөл, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд 894 халдварт өвчин бүртгэгдэж 10 000 хүн амд 76.3 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 31.2 пунктээр, улсын дунджаас 63.4 пунктээр тус тус буурсан байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 11.7 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 22.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.6. 2. Тэмбүүгийн өвчлөл, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд 297 тэмбүүгийн өвчлөл бүртгэгдэж нийт халдварт өвчний 33.2 хувийг эзэлж 10 000 хүн амд 25.4 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 5.7 пунктээр, улсын дунджаас 3.4 пунктээр тус тус өндөр үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 5.7 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 9.9 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 3. Төрөлхийн тэмбүү, 100 000 хүн амд, Өвөрхангай аймаг, 2013-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд төрөлхийн тэмбүүгийн өвчлөл бүртгэгдээгүй байна.

Зураг.6. 4. Вируст гепатит /В17-В19/-ын өвчлөл, 10 000 хүн амд, улс, аймгаар, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд вируст гепатитын 8 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.7 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 1.0 пунктээр, улсын дунджаас 0.9 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 0.2 пунктээр нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 13.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.6. 5.Гонококкт халдвар, 10 000 хүн амд, улс, аймгаар, Өвөрхангай аймаг, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд гонококкт халдварын өвчлөлийн 122 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 13.6 хувийг эзэлж, 10000 хүн амд 10.4 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 10.1 пунктээр, улсын дунджаас 7.4 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 0.7 пунктээр нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 4.0 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 6 .Сүрьеэгийн өвчлөл, 10 000 хүн амд, улс, аймгаар, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд сүрьеэгийн өвчлөлийн 58 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 5.0 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 3.7 пунктээр, улсын дунджаас 6.2 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 1.5 пунктээр нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 0.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.6. 7. Сүрьеэгийн өвчлөл, өвчний төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд сүрьеэгийн өвчлөлийн 58 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 6.5 хувийг эзэлж байгаа ба сүрьеэгийн өвчлөлийн дийлэнх хувийг уушгины сүрьеэ(46%) эзэлж байна.

Зураг.6. 8. БЗДХалдвар, нас, хүйсээр, тухайн насны 10 000 хүн амд, 2019 он




Бэлгийн замын халдварт өвчин нь 15-29 насанд эрэгтэйчүүдийн дунд их тархалттай байгаа бол, 30-аас дээш насныхны халдварын тархалтыг хүйсээр харьцуулбал эмэгтэйчүүдэд их байна.


Зураг.6. 9. Гонококкт халдвар, 10 000 хүн амд, 2019 он



Зураг.6. 10. Тэмбүүгийн халдвар, харьяаллаар, 2019 он



Зураг.6. 11. Трихомониазын халдвар,харьяаллаар, 10 000 хүн амд, 2019 он




2019 оны байдлаар 10 000 хүн амд ногдох Гонококкт халдварын түвшин аймгийн дунджаар 10.4 байгаа бол Уянсэтгэл ӨЭМТ-д хамгийн их буюу 23.4, Хайрхандулаан суманд 19.9 байна.

Тэмбүүгийн халдвар Хархорин суманд хамгийн их буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 75.1 болж аймгийн дунджаас 2.9 дахин их тархалттай байна.

Трихомониазын халдвар Хужирт суманд хамгийн их буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 26.3 болж аймгийн дунджаас 3.1 дахин их байна.


2019 оны байдлаар гонококкт халдвар бүртгэгдээгүй 6 сум, тэмбүүгийн өвчлөл бүртгэгдээгүй 2 сум, трихомониазын халдвар бүртгэгдээгүй 5 сум байна.

Зураг.6. 12. Хачигт рекиттиозын халдвар, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд хачигт рекиттиозын 8 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.7 ногдож байгаа нь аймгуудын дундажтай ижил түвшинд, улсын дунджаас 0.3 пунктээр өндөр үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 0.2 пунктээр буурч, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 0.2 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 13. Бруцеллиозын халдвар, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд бруцеллиоз өвчний 5 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 0.6 хувийг эзэлж, 10000 хүн амд 0.4 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 0.1 пунктээр бага, улсын дунджаас 0.1 пунктээр өндөр үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад ижил түвшинд, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 0.1 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 14. Гахай хавдар, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд гахай хавдар өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг.6. 15.Гар, хөл, амны өвчин, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд гар, хөл, амны өвчний 23 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 2.6 хувийг эзэлж, 10000 хүн амд 2.0 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 1.7 пунктээр, улсын дунджаас 4.6 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 8.4 пунктээр, сүүлийн 8 жилийн дундажтай харьцуулахад 0.7 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна.


Зураг.6. 16. Цусан суулга, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд цусан суулга өвчний 98 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 10.7 хувийг эзэлж, 10000 хүн амд 8.4 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 3.7 пунктээр их, улсын дунджаас 8.4 пунктээр доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 9.8 пунктээр буурч, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 2.5 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


2019 оны байдлаар аймгийн хэмжээнд салхинцэцэг өвчний 128 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 14.3 хувийг эзэлж, 10000 хүн амд 10.9 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 12.9 пунктээр, улсын дунджаас 22.0 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 5.9 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 6.3 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.6. 17. Салхинцэцэг, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд салмонеллэзын халдварын 32 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 3.6 хувийг эзэлж, 10000 хүн амд 2.7 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 2.3 пунктээр, улсын дунджаас 1.6 пунктээр тус тус дээгүүр үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 2.5 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 2.3 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 18. Сальмонеллэзын халдвар, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




Зураг.6. 19. Ёлом, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд Ёлом халдварт өвчний 11 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 1.2 хувийг эзэлж, 10000 хүн амд 0.9 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 0.4 пунктээр, улсын дунджаас 0.2 пунктээр тус тус дээгүүр үзүүлэлттэй


байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 0.5 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад мөн 0.5 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 20. Улаан эсэргэнэ, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд улаан эсэргэнэ өвчний 5 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 0.6 хувийг эзэлж, 10000 хүн амд 0.4 ногдож байгаа нь аймгуудын дунджаас 0.5 пунктээр, улсын дунджаас 2.5 пунктээр тус тус доогуур үзүүлэлттэй байна. Аймгийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 0.2 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад мөн 0.3 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Зураг.6. 21. Улаан бурхан, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд улаан бурхан өвчний тохиолдол бүртгэгдээгүй ба 2015-2016 онуудад улсын хэмжээнд улаан бурхан өвчний дэгдэлт гарч 10000 хүн амд ногдох өвчлөл 2016 онд манай аймагт 125.1, улсын дундаж 99.0-д хүрч өссөн байна.


2019 оны байдлаар аймгийн хэмжээнд менингококкт халдварын 1 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 0.1 хувийг эзэлж, 10000 хүн амд 0.1 ногдож байгаа нь улс, аймгуудын дундажтай ижил түвшинд байна. Манай аймагт 2010, 2012-2018 онуудад тус халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг.6. 22. Менингококкт халдвар, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд хачигт энцефалитын тохиолдол бүртгэгдээгүй байна. Манай аймагт 2010-2017 онуудад тус халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг.6. 23. Хачигт энцефалит, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



Манай аймагт хоолны хордлогот халдвар 2012,2013,2018 онуудад бүртгэгдсэн ба сүүлийн 10 жилд хамгийн ихдээ 2012 онд 41 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 3.7-д хүрсэн байна.

Зураг.6. 24. Хоолны хордлогот халдвар, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



Гепатитын А вирус халдвар 2015, 2017-2019 онуудад бүртгэгдээгүй ба сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн ихдээ 2011 онд 681 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 60.7-д хүрч байжээ.

Зураг.6. 25. Гепатитийн А вирусийн халдвар, тохиолдол, 10 000 хүн амд ногдох түвшин, 2010-2019 он




2019 оны байдлаар вирус В гепатитын 7 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 0.6 ногдож байгаа нь өмнөх оноос 2 тохиолдлоор буюу 0.3 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 10 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшинг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулбал 0.5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.6. 26. Гепатитийн В вирусийн халдварын тохиолдол, 10 000 хүн амд ногдох түвшин, 2010-2019 он




2019 оны байдлаар вирус С гепатитын тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг.6. 27. Гепатитийн С вирусийн халдварын тохиолдол, 10 000 хүн амд ногдох түвшин, 2010-2019 он



ГЕПАТИТИЙН БУСАД ВИРУСИЙН ХАЛДВАР

Зураг.6. 28. Гепатитийн Дельта вирусийн халдварын тохиолдол, 10 000 хүн амд ногдох түвшин, 2010-2019 он



2019 оны байдлаар вирус Д гепатитын 1 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 0.1 ногдож байгаа нь өмнөх онтой ижил түвшинд байна. 10 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшинг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулбал 0.04 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 29.БЗДХ тохиолдол, 10 000 хүн амд ногдох түвшин, 2010-2019 он



2019 оны байдлаар БЗДХ-ын нийт 517 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 44.5 ногдож байгаа нь өмнөх оноос 133 тохиолдлоор буюу 11.4 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 10 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшинг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулбал 16.7 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг.6. 30.Бэлгийн замын халдварт өвчин, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он




Бэлгийн замаар дамжих халдварын дийлэнх хувийг тэмбүүгийн халдвар эзэлж байна. 2019 оны байдлаар тэмбүүгийн өвчлөл 57.4 хувийг, 10 жилийн дунджаар 57.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг.6. 30. Төрөлхийн тэмбүүгийн халдвар, 100 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин, 2010-2019 он




2019 оны байдлаар төрөлхийн тэмбүүгийн халдвар бүртгэгдэгүй байна.

Зураг.6. 31. Халдварт өвчний шалтгаант нас баралт, Өвөрхангай аймаг, 2011-2019 он




2019 оны байдлаар халдварт өвчний шалтгаант нас баралтын 1 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 0.9 ногдож байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд 2015 онд халдварын шалтгаант нас баралт бүртгэгдээгүй бол 2016 онд хамгийн их буюу нас баралтын 8 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 7.1 ногдож байсан байна.

Зураг.6. 32. Бүртгэгдсэн нийт халдварт өвчин, төрлөөр, 2018, 2019он



Зураг.6. 33. Бэлгийн замаар дамжих халдвар, тохиолдлын тоогоор, 2014-2019 он



БҮЛЭГ VII. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

Тогтвортой хөгжлийн зорилтын 3.4-т 2030 он гэхэд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг гуравны нэгээр бууруулах, 3.8-д хүн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох, эрүүл мэндтэй холбоотой санхүүгийн эрсдэлээс хамгаалж, нэн шаардлагатай, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аюулгүй, үр дүнтэй, чанартай, боломжийн үнэтэй зайлшгүй шаадлагатай эм, вакцинаар хангах гэж тусгасан байдаг. Дэлхийн улс орнуудад бүх насны хүмүүс халдварт бус өвчинд өртөж байгаа бөгөөд зөв төлөвлөөгүй хотжилт, эрүүл бус амьдралын хэв маяг, тамхины хэрэглээ, эрүүл бус хоололт, бие махбодийн идэвхигүй байдал, архины хортой хэрэглээ зэрэг хүчин зүйлүүд нь 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн үзүүлэлтийн хүрэх үр дүнд шууд нөлөөлөхөөр байна.

Эх үүсвэр: <http://www.who.int/news-room/fact-sheets/detail/noncommunicable-diseases>

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоолсноор орчноос хамааралтай халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаанд цус харвалт, зүрхний шигдээс, санамсаргүй осол гэмтэл, хавдар, амьсгалын замын архаг өвчин, астма, амьсгалын дээд замын цочмог өвчлөл, нярайн өвчин, санаатай осол гэмтэл зэрэг өвчнүүдийг оруулсан байна. Манай улсын хүн амын өвчлөлийн хэв маягт 1990-ээд оноос эхлэн тархвар зүйн өөрчлөлт орж, хүн амын дунд халдварт бус өвчлөл, үүнээс шалтгаалсан нас баралт нэмэгдсээр байна. ДЭМБ-аас улс орнуудын халдварт бус өвчний байдалд дараах гурван төрлийн хяналтыг тавьж байна.

Хүснэгт.7. 1. Халдварт бус өвчний тохиолдлын тоо, Өвөрхангай аймаг, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Амьсгалын дээд замын цочмог халдвар /J00-06/	3845	3012	2725	1826	1882	1919	2409	3003	2491	3842
Хатгалгаа /J12-J18/	1021	1105	1048	786	1440	769	1235	1285	1404	1405
Цочмог бронхит /J20-J22/	1368	1166	1256	699	1486	910	1043	1966	2268	3207
Томуу /J10-J11//	3447	1894	1404	1438	1503	1165	1634	1871	1617	2069
Уушгины архаг бөглөрөлт өвчин /J40-44/	560	898	602	523	518	712	705	784	527	835
Гүйлсэн булчирхай ба аденоидын архаг өвчин /J35/	495	415	738	529	486	596	486	670	626	610
Бусад өвчин	712	689	794	889	880	943	1064	1467	1411	1756
Нийт /J00-99 /	11448	9179	8567	6690	8195	7014	8576	11046	10344	13724

Халдварт бус өвчний дэлхийн хяналтын тогтолцоо

✚ Өвчлөл ба нас баралт

Амьсгалын замын архаг өвчлөл, чихрийн шижин, хавдар, зүрх судасны өвчин 30-70 нас
Хавдар өвчний түвшин, хавдрын төрлөөр

✚ Эрсдэлт хүчин зүйл

Архины хортой хэрэглээ (3) Жимс, ногооны бага хэрэглээ Хөдөлгөөний дутагдал (2) Давсны хэрэглээ Ханасан өөх тосны хэрэглээ Тамхины хэрэглээ (2) Цусан дахь сахар ихсэх/чихрийн шижин Цусны даралт ихсэх Жингийн илүүдэл, таргалалт (2) Холестрины хэмжээ ихсэх

✚ Үндэсний тогтолцоо, хариу арга хэмжээ


Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг Эмийн эмчилгээ, зөвлөгөө өгөх ХБӨ-ний зайлшгүй шаардлагатай эм, технологи Гепатит В-ийн вакцин Хүний папилома вирусийн вакцин Хүүхдийн хүнсний хангамж, хэрэглээ Хөнгөвчлөх эмчилгээний тусламж үйлчилгээ Ханасан өөх тосыг хязгаарлах, хэрэглээг хориглох бодлого

Зураг.7. 1. Халдворт бус өвчлөл, улс, аймгаар, 1000 хүн амд, 2010-2019 он




Аймгийн хэмжээнд хүн амын өвчлөлийн тохиолдол 68779 (давхардсан тоогоор)-д хүрч 1000 хүн амд 591.9 ногдож өмнөх оноос 78.6 пунктээр, сүүлийн 10 жилийн дунджаас 109.2 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мана аймгийн хүн амын өвчлөлийг түвшинг аймгуудын дундажтай харьцуулахад ойролцоо түвшинд байгаа бол улсын дундаж үзүүлэлтээс харьцангуй доогуур түвшинд байна.

Зураг.7. 2. Халдварт бус өвчин, насны бүлгээр, тухайн насны 1 000хүн амд, 2015, 2019 он




2019 онд бүртгэгдсэн халдварт бус өвчнийг насны бүлгээр авч үзвэл 0-4 насны 1 000 хүүхдэд ногдох өвчлөл хамгийн их буюу 497.6 байгаа бол 20-24 насныхны өвчлөлийн түвшин хамгийн бага буюу 32.6 байна.

Зураг.7. 3. Хүн амын өвчлөлийн тохиолдол, эмнэлгийн төрлөөр, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд өвчлөлийн 68779 тохиолдол бүртгэгдснээс 62.6 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 16.9 хувь нь сумын эрүүл мэндийн төвд, 11.6 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвд, 7.6 хувь нь Хархорин нэгдсэн эмнэлэгт, 1.4 хувь нь хувийн хэвшлийн эмнэлэгт тус тус бүртгэгдсэн байна.

Зураг.7. 4. Хүн амын өвчлөлийн түвшин, 1 000 хүн амд, хүйсээр, 2010-2019 он




2019 оны байдлаар 1 000 эмэгтэйд ногдох өвчлөл 732 байгаа нь эрэгтэйчүүдээс 286 пунктээр, аймгийн дунджаас 142 пунктээр тус тус өндөр үзүүлэлттэй байна. Эмэгтэйчүүдийн дундах өвчлөлийн түвшин өндөр байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн нас баралтын түвшин эрэгтэйчүүдийнхээс бага буюу дундаж наслалт өндөр байсаар байна.

Зураг.7. 5. Амьсгалын тогтолцооны өвчний түвшин, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөлийн 13724 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 1181.2 ногдож байгаа нь өмнөх оноос 290.7 пунктээр, сүүлийн 10 жилийн дунджаас 345.8 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бол 2019 оны улсын дунджаас 917.8 пунктээр доогуур үзүүлэлттэй байна.


Зураг.7. 6 Амьсгалын тогтолцооны өвчний түвшин, Өвөрхангай аймаг, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он




Амьсгалын тогтолцооны өвчний түвшинг 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад бүх насанд нэмэгдэж, 2019 оны байдлаар, насны бүлгээр харвал 0-4 насны 10 000 хүүхдэд ногдох өвчлөл 4976 болж 10 жилийн өмнөхөөс 835-аар нэмэгдэж, 2019 оны байдлаар 48.9 хувийг 0-4 насны хүүхдийн өвчлөл эзэлж байгаа нь улсын дунджаас 2.0 пунктээр их байна.

Амьсгалын тогтолцооны өвчнүүдийн бүтцийг 2019 онд амьсгалын дээд замын цочмог халдвар 28.0 хувийг эзэлж улсын дунджаас 2.8-аар бага, хатгалгаа 10.2 хувийг эзэлж улсын дунджаас 7.6 пунктээр бага, цочмог бронхит 23.4 хувийг эзэлж улсын дунджаас 9.3-аар их, томуу 15.1 хувийг эзэлж улсын дунджаас 6-аар их, уушгины архаг бөглөрөлт өвчин 6.1 хувийг тус тус эзэлж байна.

Зураг.7.7 Амьсгалын тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10 000 хүн амд, 2010,2015,2019 онуудаар



Зураг.7.8 Амьсгалын тогтолцооны өвчин, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он




7.3.ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН ТОГТОЛЦОО

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон хоол боловсруулах тогтолцооны өвчлөл (10 000 хүн амд) 2019 онд 1313 болж, сүүлийн 10 жилийн дундажаас 248-аар, өмнөх оноос 76-аар тус тус өссөн байна. Харин хоол боловсруулах тогтолцооны өвчний түвшин, 2019 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 965 болж улсын дундажаас 516-аар бага, аймгийн 10 жилийн дундажаас 224-өөр их, эмэгтэйчүүдийнх 1658 болж улсын дундажаас 541-ээр бага, аймгийн 10 жилийн дундажаас 272-оор их байна.

Зураг.7. 9 Хоол боловсруулах тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүнд амд, 2010-2019 он




Зураг.7. 10. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн түвшин, хүйсээр, 10 000 хүнд амд, 2010-2019 он



Хоол боловсруулах тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2010, 2019 оныг харьцуулан харвал насны бүлэг дэх өвчлөл нэмэгдсэн байна. 2019 онд 5-9 насны 10 000 хүүхдэд ногдох өвчлөл хамгийн их буюу 2034.7 болж, 2010 оныхоос 482-оор, 2015 оныхоос 590-ээр нэмэгдсэн байна.

Зураг.7. 11. Хоол боловсруулах тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10 000 хүн амд, 2010, 2015, 2019 он



Хүснэгт.7. 2. Хоол боловсруулах замын өвчлөл, тэргүүлэх шалтгаан, тохиолдлын тоогоор, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин /k00-k14/	3261	5506	6298	5584	6067	7171	6124	8471	7949	8505
Улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин /k-20-31/	1947	1984	1471	2075	1756	2242	1999	2442	2089	2448
Элэгний өвчин /k70-77/	984	780	502	993	1150	875	613	1386	1959	926
Цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин /k80-87/	817	962	737	1137	1384	1391	1422	1847	1138	1370
Халдварт бус энтерит ба колит /k50-52/	871	636	643	645	867	578	644	811	729	1297
Мухар олгойн өвчин /k35-38/	373	367	249	251	338	291	289	304	273	330
Хоол боловсруулах тогтолцооны бусад өвчин	186	204	171	184	232	214	231	290	241	388
Нийт	8439	10439	10071	10869	11794	12762	11322	15551	14378	15264

УЛААН ХООЛОЙ, ХОДООД, ДЭЭД ГЭДЭСНИЙ ӨВЧНҮҮД


Улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчний дотор гастрит ба дуоденит 90.4 хувийг эзэлж улсын дунджаас 15.8 пунктээр их үзүүлэлттэй байна.

Зураг.7. 12 Гастрит ба дуоденит өвчний тохиолдол, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар улаан хоолой, ходоод, дээд гэдэсний замын 2448 бүртгэгдэж сүүлийн 10 жилийн дунджаас 403-аар өссөн ба хүйсээр авч үзвэл 10 000 хүн амд ногдох өвчлөл 10 жилийн дунджаар эмэгтэйчүүдэд 245.6 болж эрэгтэйчүүдийн өвчлөлөөс 131.5-аар буюу 2.2 дахин их байна.

Зураг.7. 13 Улаан хоолой, ходоод дээд гэдэсний өвчлөл, Өвөрхангай аймаг, 2010-2019 он




Хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний өвчин 2019 оны байдлаар 6.1 хувийг эзэлж улсын дунджаас 5.7 пунктээр бага байна.

Элэгний өвчлөл дунд архаг гепатит өвчин дийлэнх хувийг эзэлж байгаа ба 2019 онд 75.9 хувийг, 10 жилийн дунджаар 69.2 хувийг тус тус эзэлж байна.

Зураг.7. 14 Элэгний зарим өвчлөл, тохиолдлын тоо, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Архаг гепатит /k73/	691	530	307	628	686	512	385	1151	1760	703
Элэгний хатуурал /k74/	193	144	101	223	249	195	115	86	92	96
Элэгний хордлогот өвчин	10	7	23	12	20	14	18	24	4	13
Архины шалтгаант элэгний өвчин /k70/	6	3	5	2	2	3	1	6	3	4
Элэгний бусад өвчин	1110	1327	1576	1148	1057	1291	1497	750	159	1203

Зураг.7. 15 Элэгний зарим өвчлөл, байршил, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он




7.4.ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааны нэг болох зүрх судасны тогтолцооны өвчлөл 2019 онд 8070 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 694 болж улсын дунджаас 626-аар их байна. Харин зүрх судасны тогтолцооны өвчний түвшинг 2019 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 555.5 болж, 10 жилийн дундажаас 125-аар, эмэгтэйчүүдийнх 832 болж, 10 жилийн дундажаас 23-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг.7. 16 Зүрх судасны тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүн амд, 2016-2020 он




Зураг.7. 17 Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшин, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



Зүрх судасны тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2010, 2015, 2019 оныг харьцуулан харвал 55-аас дээш насныхны өвчлөл нэмэгдсэн байна. 2019 онд 65-аас дээш насанд хамгийн их буюу 4217 болж, 2010 оныхоос 1.5 дахин, 2015 оныхоос 1.3 дахин нэмэгдсэн байна.

Зураг.7. 18 Зүрх судасны тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүн амд, 2010, 2015, 2019 он




Зүрх судасны тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 10000 хүн амд ногдох өвчлөл 2019 оны байдлаар цусны даралт ихсэх өвчнүүд 64.9 хувийг эзэлж улсын дунджаас 15.2-оор их, зүрхний ишеми өвчин 12.2 хувийг эзэлж улсын дунджаас 8.4-өөр их, тархины судасны өвчин 4.4 хувийг эзэлж улсын дунджаас 8.9-өөр бага, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд 5.0 хувийг эзэлж улсын дунджаас 1.0-ээр бага, хэрлэгийн гаралтай зүрхний өвчин 7.0 хувийг эзэлж улсын дунджаас 3.0-аар их, артер, артериол, хялгасан судасны өвчин 0.5 хувийг эзэлж улсын дунджаас 1.1-ээр бага үзүүлэлттэй байна. Өвчлөлийн бүтцийг хүйсээр харвал хэрлэгийн гаралтай зүрхний өвчин, цусны даралт ихсэх өвчнүүд эмэгтэйд илүү, зүрхний ишемит өвчин, тархины судасны өвчин, артери, артериол, хялгасан судасны өвчин, вен, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд, зүрх судасны бусад өвчин эрэгтэйд илүү хувийг эзэлж байна.

Зураг.7. 19 Зүрх судасны тогтолцооны тэргүүлэх өвчнүүд, тохиолдлын тоогоор, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт тохиолдлын тоо	6566	6475	5807	7441	7530	7223	7022	7157	6997	8070
Цусны даралт ихсэх өвчнүүд /i10-15/	3482	3193	2851	3451	3728	4127	4338	4205	4292	5213
Зүрхний ишемит өвчин /I20-I25/	811	840	841	1032	1068	1055	830	859	789	983
Тархины судасны өвчин /I60-69/	239	194	430	894	843	475	581	836	776	355
Вен, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд /I80-89/	122	163	173	197	222	201	200	270	288	407
Хэрлэгийн гаралтай зүрхний өвчнүүд /I00-I09/	1638	1863	1308	1669	1463	1103	786	721	569	564
Артери, артериол, хялгасан судасны өвчин /I70-79/	18	9	23	27	41	14	15	26	26	39
Зүрх судасны бусад өвчин	256	213	181	171	165	248	272	240	257	509


Зураг.7. 20 Зүрх судасны тогтолцооны тэргүүлэх өвчнүүд, дүнд эзлэх хувиар,2010-2019 он



ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭХ ӨВЧИН

Цусны даралт ихсэх өвчин зүрх судасны тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар 48.1 хувийг эзэлж улсын дундажаас 1.2-оор их байна. Цусны даралт ихсэх өвчнийг 10 000 хүн амд, 2019 оны байдлаар 448 болж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад аймгийн хэмжээнд 151-ээр өсчээ. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд 10 000 хүн амд 574.1, эрэгтэйчүүд 10000 хүн амд 322.0 тохиолдож байна.


Зураг.7. 21 Цусны даралт ихсэх өвчин, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



ЗҮРХНИЙ ИШЕМИ ӨВЧИН

Зүрхний ишеми өвчин зүрх судасны тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар 23.0 хувийг эзэлж, 2019 оны байдлаар 10.7 болж улсын дундажаас 9.9-ээр бага, аймгийн 10 жилийн дундажаас 0.8 хувиар буурсан байна. Зүрхний ишеми өвчнийг 10 000 хүн амд, 2019 оны байдлаар 84.6 болж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад аймгийн хэмжээнд 3.7-оор өсчээ. Хүйсийн хувьд 10 000 хүн амд эмэгтэйчүүд 73,5, эрэгтэйчүүд 95.8 тохиолдож байна.


Зураг.7. 22 Зүрхний ишеми өвчин, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



ТАРХИНЫ СУДАСНЫ ӨВЧИН

Тархины судасны өвчин зүрх судасны тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар 7.8 хувийг эзэлж улсын дундажаас 3.8-аар бага байна. 2019 оны байдлаар 4.4 болж улсын дундажаас 8.9-өөр, аймгийн 10 жилийн дундажаас 3.4 хувиар тус тус буурсан байна. Тархины судасны өвчнийг 10 000 хүн амд, 2019 оны байдлаар өвч үзвэл 483 байна. 2019 оны байдлаар хүйсийн хувьд 10 000 хүн амд эмэгтэйчүүд 29.5 эрэгтэйчүүд 31.7 тохиолдож байна.

Зураг.7. 23. Тархины судасны өвчин, 10 000 хүн амд, 2010-2019 он



ШЭЭС БЭЛГИЙН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН


Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2019 онд сувганцрын өвчнүүд 45.3 хувийг эзэлж улсын дундажаас 5.4-өөр бага, эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт өвчин 30.3 хувийг эзэлж улсын дундажаас 14.2-оор их, эм бэлэг эрхтний үрэвсэлт бус өвчин 8.7 хувийг эзэлж улсын дундажаас 0.5-аар бага, шээс ялгаруулах тогтолцооны бусад өвчин 3.2 хувийг эзэлж улсын дундажаас 4.8-аар бага, эр бэлэг эрхтний өвчнүүд 4.7 хувийг эзэлж улсын дундажаас 2.8-аар бага, хөхний өвчин 2.9 хувийг эзэлж улсаам 0.2-оор их, бөөрний түүдгэнцрийн өвчнүүд 2.2 хувь, бөөрний дутмагшил 2.2 хувь, шээс чулуужих өвчин 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт.7. 3 Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, өвчний төрлөөр, бодит тоо, 2010-2019 он


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт өвчлөл	7239	6868	6044	7713	5583	6862	7967	7275	6572	8791
Сувганцарын өвчнүүд N10-N16	4075	3274	3167	3992	3212	4328	4573	3676	3017	3986
Эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт N70-N77	1728	2337	1616	2312	1072	1268	2177	2201	2132	2665
Эм бэлэг эрхтэний үрэвсэлт бус N80-N99	419	317	239	280	289	460	432	378	456	765
Шээс ялгаруулах бусад N25-N39	216	213	215	182	171	141	171	250	234	284
Эр бэлэг эрхтэний өвчнүүд N40-N51	77	146	238	151	130	153	125	257	337	413
Хөхний өвчин N60-N64	77	146	132	175	155	145	131	177	171	263
Түүдгэнцрийн өвчнүүд N00-N08	587	401	409	518	491	259	262	227	103	190
Бөөрний дутмагшил N17-N19	47	17	19	92	33	89	75	90	91	194
Шээс чулуужих өвчин N20-N23	13	17	9	11	30	19	21	19	31	31

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааны нэг болсон шээс бэлгийн тогтолцооны өвчлөл (10 000 хүн амд ногдох) 2019 онд 756.6 болж улсын дундажаас 363.4-өөр бага, аймгийн сүүлийн 10 жилийн дундажаас 123-аар, өмнөх оноос 190.9-аар тус тус өссөн байна. Харин шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшинг 2019 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 279.7 болж, 10 жилийн дундажаас 66.6-аар, эмэгтэйчүүдийнх 1228.7 болж, 10 жилийн дундажаас 180.1-ээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг.7. 24 Шээс бэлгийн тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүн амд, хүйсээр, 2010-2019 он




Зураг.7. 25 Шээс бэлгийн тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүн амд, хүйсээр, 2010-2019 он



Шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2010, 2015, 2019 оныг харьцуулан 15-24 насныхнаас бусад насны бүлэг дэх өвчлөл нэмэгдсэн байна. 2019 онд тухайн насны 10000 хүн амд ногдох өвчлөл 30-34 насанд хамгийн их буюу 1395 болж, 2010 оныхоос 1.2 дахин, 2015 оныхоос 1.3 дахин нэмэгдсэн байна.

Зураг.7. 26 Шээс бэлгийн тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10 000 хүнд ногдох, 2010,2015,2019 он



БӨӨРНИЙ СУВГАНЦРЫН ЗАВСРЫН ЭДИЙН ӨВЧИН


Бөөрний сувганцрын завсрын эдийн өвчин шээс бэлгийн тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар 52.0 хувийг эзэлж улсын дундажаас 3.0-аар бага хувийг эзэлж, 2019 оны байдлаар 45.3 хувь болсон нь 10 жилийн дундажаас 6.6 хувиар буурсан байна. 2019 оны байдлаар эмэгтэйчүүд 10 000 хүн амд 520.5, эрэгтэйчүүд 10000 хүн амд 163.8 ногдож, эмэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 3.2 дахин их байна.

Зураг.7. 27. Бөөрний сувганцрын завсрын эдийн өвчин, тохиолдлын тоо, хувиар, 2010-2019 он



2019 оны байдлаар бөөрний сувганцрын завсрын эдийн өвчний 3986 тохиолдол бүртгэгдэж шээс бэлгийн тогтолцооны өвчлөлд 45.3 хувийг эзэлж байна.

Зураг.7. 28 Бөөрний сувганцрын завсрын эдийн өвчин, Өвөрхангай аймаг, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар нийт тохиолдлын тоо 3986 байгаа нь сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 256 тохиолдлоор нэмэгдсэн байна.

МЭДРЭЛИЙН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН

Мэдрэлийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2019 онд мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг 33.4 хувь, толгой өвдөх, мигрень 22.8 хувь, эпилепси, уналт 11.1 хувь, дистони 3.3 хувь, тархины саа ба саажилтын хам шинж 2.1, тархины цус багасах дайралт ба түүнд хамаарах хамшинжүүд 7.1 хувь, төв мэдрэлийн тогтолцооны үрэвсэлт өвчнүүд 1.1 хувь, мэдрэлийн тогтолцооны бусад эмгэг 19.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт.7. 4 Мэдрэлийн тогтолцооны өвчлөлийн төрөл, бодит тоогоор, 2010-2019 он


Тэргүүлэх өвчлөлүүд	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг G50-G59	634	832	881	1136	1295	1187	1401	2382	2074	1012
Мигрень, толгой өвдөх G43-44	1034	1301	964	428	346	469	525	1215	1210	690
Эпилепси, уналт G40-41	740	591	488	322	567	469	475	578	503	335
Дистони G24	254	207	266	286	187	219	98	134	76	101
Тархины саа ба саажилтын хам шинж G80-83	194	227	228	46	136	172	100	171	150	65
Тархины цус багасах дайралт ба түүнд хамаарах хамшинжүүд G45	253	74	114	66	53	12	41	150	194	215
Төв мэдрэлийн тогтолцооны үрэвсэлт өвчнүүд G01-09	32	37	47	45	63	66	43	40	40	33
Мэдрэлийн тогтолцооны бусад эмгэг	272	414	490	642	798	447	407	676	508	575
НИЙТ	3413	3683	3478	2971	3445	3041	3090	5346	4755	3026

Хүн амын өвчлөлийн тавдугаар шалтгаан болсон мэдрэлийн тогтолцооны өвчлөл (10 000 хүн амд ногдох) 2019 онд 260 болж, сүүлийн 10 жилийн дундажаас 59-өөр, өмнөх оноос 149-өөр тус тус буурсан байна. Харин мэдрэлийн тогтолцооны өвчний түвшинг 2019 оны байдлаар хүйсээр харвал эрэгтэйчүүдийнх 1069 болж, 10 жилийн дундажаас 303-аар, эмэгтэйчүүдийнх 1957 болж 10 жилийн дундажаас 295-аар тус тус буурсан байна.

Зураг.7. 29 Мэдрэлийн тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүн амд, хүйсээр, 2010-2019 он




Зураг.7. 30 Мэдрэлийн тогтолцооны өвчний тохиолдлын түвшин, 10 000 хүн амд, хүйсээр, 2010-2019 он




Мэдрэлийн тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2010, 2015, 2019 оныг харьцуулан харвал 0-9 нас болон 60-аас дээш насанд нэмэгдэж бусад насны бүлэг дэх өвчлөл буурсан байна. 2019 онд 60-64 насанд хамгийн их буюу 511 байна.

Зураг.7. 31 Мэдрэлийн тогтолцооны өвчин, насны бүлгээр, 10 000 хүн амд, 2010, 2015, 2019 он



Зураг.7. 32 Мэдрэлийн тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он




Зураг.7. 33 Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг, хүйсээр 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэгийн 1012 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 87.1 байгаа нь өмнөх оноос 91.4-өөр, 10 жилийн дундажаас 25.9-өөр тус тус буурсан байна.


Зураг.7. 34 Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он




МИГРЕНЬ, ТОЛГОЙ ӨВДӨХ ӨВЧИН

Мигрень, толгой өвдөх өвчин мэдрэлийн тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар 22.6 хувийг эзэлж улсын дундажаас 1.3-аар их, 2019 оны байдлаар 22.8 хувь болсон нь 10 жилийн дундажаас 0.2 хувиар ихэссэн байна. Харин 10 000 хүн амд, 2019 оны байдлаар 59.4 болж сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 12.7 -оор буурсан байна. Хүйсийн хувьд 10 жилийн дундажаар 10 000 эмэгтэй хүн амд 101.9 ногдож 2019 онд 42.5-аар, 10000 эрэгтэй хүн амд 42.1 ногдож 2019 онд 12.7-оор тус тус буурсан байна.

Зураг.7. 35 Мигрень, толгой өвдөх, хүйсээр, 10 000 хүн амд, улс, аймгаар, 2010-2019 он




Зураг.7. 36 Мигрень, толгой өвдөх, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



ДОТООД ШҮҮРЭЛ, ТЭЖЭЭЛИЙН БА БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ӨВЧИН


2019 оны байдлаар дотоод шүүрэл бодисын солилцооны өвчний 1494 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 128.6 ногдож байгаа нь 10 жилийн дунджаас 586 тохиолдлоор буюу өвчлөлийн түвшин 48.7-оор буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.7. 37 Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, Өвөрхангай аймаг, 2010-2019 он




2019 оны байдлаар дотоод шүүрэл, бодисын солилцооны өвчлөл 1494 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 128.6 ногдож байгаа ба хүйсээр авч үзвэл 10 000 эмэгтэйд 155.9 ногдож байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 1.5 дахин бага үзүүлэлттэй байна.

Зураг.7. 38 Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, Өвөрхангай аймаг, хүйсээр, 2010-2019 он



Дотоод шүүрлийн тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2010, 2015, 2019 оныг харьцуулан харвал 0-4 наснаас бусад насны бүлэг дэх өвчлөл буурсан байна. 2019 онд 55-59 насанд хамгийн их буюу 375 байна.


Зураг.7. 39 Дотоод шүүрлийн тогтолцооны өвчин, насаар, 10 000 хүн амд, Өвөрхангай аймаг, 2010, 2015, 2019 он



ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ӨВЧЛӨЛ

Чихрийн шижин өвчин нь дотоод шүүрэл, тэжээлийн бодисын солилцооны өвчлөлийн 34.5 хувийг эзэлж байгаа бол улсын дундаж 42.9 хувь байна. 2019 онд 10000 хүн амд 59.3 байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 10 000 хүн амд 64.9, эмэгтэйчүүд 10 000 хүн амд 53.8 байна.


Зураг.7. 40 Чихрийн шижин өвчин, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019




АРЬСНЫ ӨВЧИН

2019 оны байдлаар арьсны өвчний 5226 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 449.8 ногдож 10 жилийн дунджаас 125.1-ээр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг.7. 41 Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин, Өвөрхангай аймаг, 10 000 хүн амд, 2010-2019 он




Зураг.7. 42 Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин, Өвөрхангай аймаг, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



СЭТГЭЦ БА ЗАН ТӨРХИЙН ЭМГЭГ

Сэтгэц зан төрхийн эмгэгийг сүүлийн 10 жилээр авч үзвэл 5263 тохиолдол бүртгэгдэж эрэгтэйчүүд 43.2, эмэгтэйчүүд 56.8 хувийг эзэлж байна. 2019 оны байдлаар 476 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 40.9 байна.

Зураг.7. 43 Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг, Өвөрхангай аймаг, 10000 хүн амд, 2010-2019 он




ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ

Улсын хэмжээнд хортой ба хоргүй хавдар өвчин давхардсан тоогоор 2019 онд 67.7 мянга бүртгэгдэж, нийт өвчлөлийн 1.9 хувийг, хортой хавдар 42.7 мянга бүртгэгдэж нийт хавдрын 63.0 хувийг эзэлж байна.

Хавдрын тохиолдлын түвшинг (10 000 хүнд ногдох) сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2019 онд аймгийн хэмжээнд 19.1 болж улсын дундажаас 0.1 пунктээр их, аймгийн сүүлийн 10 жилийн дундажаас 5.1-ээр тус тус нэмэгдэж, өмнөх оноос 1.1-ээр буурсан байна. Монгол Улсын хэмжээнд 2019 онд хорт хавдрын шинэ тохиолдол 6 045 бүртгэгдсэн бол манай аймагт 222 тохиолдол бүртгэгдэж улсын дүнгийн 3.7 хувийг эзэлж байна.

Зураг.7. 44. Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, 10 000 хүн амд, 2016-2019 он



2014-2019 онуудад хорт хавдрын 1110 тохиолдол бүртгэгдсэнээс 0-25 насны хүүхэд, залуучуудад хорт хавдрын 18 тохиолдол бүртгэгдэж нийт тохиолдлын 1.6 хувийг эзэлж байна.


Хүснэгт.7. 5 0-25 насанд тохиолдож буй хорт хавдрын бүтэц, Өвөрхангай аймаг, 2014-2019 он тохиолдлын тоогоор

Төрөл	2014	2015	2016	2017	2018	2019
Яс ба үений мөгөөрсний өмөн			2			3
Бусад холбох ба зөөлөн эдийн өмөн						1
Төмсөгний өмөн					1	
Бөөрний дээд булчирхайн өмөн					1	
Лимфолейкоз	1		1		3	
Элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн			1	1		
Хожкины буюу уутанцрын лимфом				1		
Миелолейкоз				1		
Тархины өмөн	1					

Хүснэгт.7. 6 Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, тохиолдлын тоогоор, 2010-2019 он

Хорт хавдрын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт хорт хавдар	120	122	120	119	133	112	186	222	235	222
Элэг /C22/	47	40	43	47	41	38	76	95	80	76
Ходоод /C16/	5	12	13	19	28	10	23	24	24	26
Уушги /C34/	12	9	9	9	8	10	14	18	16	13
Улаан хоолой /C15/	7	16	11	5	11	16	11	11	19	19
Умайн хүзүү /C53/	12	7	10	7	8	6	11	9	10	5
Бүдүүн гэдэсний өмөн /C18/	2	1	3	4	4	6	8	6	11	7
Бусад	35	37	31	28	33	26	43	59	75	76

Зураг.7. 45 Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он




ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДАР

Элэгний анхдагч хорт хавдар үүсэх гол шалтгаан нь гепатит В (HBV), С (HCV) эсвэл дельта (HDV) вирусийн архаг халдвар, түүнчлэн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс үүдэлтэй гэдэг нь судалгаагаар тогтоогдсон. Монгол Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд элэгний хорт хавдрын 9310 шинэ тохиолдол бүртгэгдсэн бол манай аймгийн хэмжээнд 583 тохиолдол бүртгэгдэж 6.3 хувийг экэлж байна. Элэгний хорт хавдар нь манай аймагт сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хорт хавдрын тэргүүлэх шалтгаан болж 36.6 хувийг эзэлж байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийг хүйсээр, дүнд эзлэх хувиар харвал 2019 онд нийт өвчлөгчдийн 69.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж, сүүлийн 10 жилийн дундажаас 8.7 пунктээр буурсан байна. Харин эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2019 онд 30.8 болж, эрэгтэйчүүдээс 38.4 пунктээр бага, сүүлийн 10 жилийн дундажаас 8.7 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг.7. 46 Элэгний хорт хавдрын өвчлөл, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



Зураг.7. 47 Элэгний хорт хавдрын өвчлөл, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он




УУШГИНЫ ХАВДАР

Уушгины хорт хавдрыг үүсгэдэг гол хүчин зүйл нь хүн амын амьдралын дадал зуршил, хоол хүнс, хүрээлэн буй орчин зэрэг байдаг. Монгол Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд уушгины хорт хавдрын 4182 шинэ тохиолдол бүртгэгдсэн бол манай аймагт 118 тохиолдол бүртгэгдэж улсын дүнгийн 2.8 хувийг эзэлж байна байна. Аймгийн хэмжээний уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшинг 2019 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 1.6

болж улсын дундажаас 0.9 пунктээр, аймгийн 2010 оны үзүүлэлтээс 0.6-аар тус тус бага үзүүлэлттэй байна. 2019 онд 10 000 эмэгтэйд ногдох мэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин 0.7 байна.


Зураг.7. 48 Амьсгуурс ба уушгины хорт хавдар, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



ХОДООДНЫ ХАВДАР

Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, тамхи татах, жимс жимсгэнэ, хүнсний ногооны хэрэглээ бага байх, хелико бактерийн халдвар, удамшлын генийн өөрчлөлт зэрэг нь ходоодны хавдрын эрсдэлт хүчин зүйлс болдог. Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд ходоодны хорт хавдрын 8137 шинэ тохиолдол бүртгэгдсэн бол манай аймагт 184 тохиолдол бүртгэгдэж улсын дүнгийн 2.3 хувийг эзэлж байна. Манай аймагт 2019 онд ходоодны хорт хавдрын 26 шинэ тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дундажаас 8-аар, өмнөх оноос 2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин (10 000 хүн амд) 2019 онд 2.2 байна.


Зураг.7. 49 Ходоодны хорт хавдрын өвчлөл, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН ХОРТ ХАВДАР, ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ТӨРӨЛ, ХҮЙС


Шинээр бүртгэгдсэн хорт хавдар нь үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлээс хамааран хүйеийн хувьд ялгаатай байна. Доорх зургуудад хорт хавдрын эзлэх хувийг хүйсээр харуулав.

Зураг.7. 50 Уушигны хорт хавдар, хүйсээр, эзлэх хувь, 2015-2019 он




Уушгины хорт хавдрын дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж сүүлийн 5 жилийн дунджаар 72.7 хувьтай буюу эмэгтэйчүүдээс 45.4 пунктээр их байна.

Зураг.7. 51 Улаан хоолойн хорт хавдар, хүйсээр, эзлэх хувь, 2015-2019 он




Улаан хоолойн хорт хавдрын өвлөлийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж сүүлийн 5 жилийн дунджаар 51.7 хувьтай буюу эрэгтэйчүүдээс 3.4 пунктээр их байна.

Зураг.7. 52 Элэгний хорт хавдар, хүйсээр, эзлэх хувь, 2015-2019 он



Шинээр бүртгэгдсэн элэгний хорт хавдрын өвлөлийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж сүүлийн 5 жилийн дунджаар 54.7 хувьтай буюу эрэгтэйчүүдээс 9.4 пунктээр их байна.


Зураг.7. 53 Ходоодны хорт хавдар, хүйсээр, эзлэх хувь, 2015-2019 он




Шинээр бүртгэгдсэн ходоодны хорт хавдрын өвлөлийн дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж сүүлийн 5 жилийн дунджаар 65.2 хувьтай буюу эмэгтэйчүүдээс 30.4 пунктээр их байна.

ХАВДРЫН ХЯНАЛТ

Зураг.7. 54 Хорт хавдрын өвлөлийн оношлогдох үеийн эмнэлзүйн үе шат, дүнд эзлэх хувиар



Зураг.7. 55 Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, эмнэлзүйн үе шат, 2019 он



ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН



Хүснэгт.7.7 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, хүйсээр, 2019 он

Өвчний ангилал	2015		2016		2017		2018		2019	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Амьсгалын тогтолцооны өвчин	2051	1922	2609	2418	2328	2160	2407	2203	2407	2203
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1231	1436	1293	1538	1288	1478	1355	1531	1355	1531
Мэдрэлийн тогтолцооны өвчин	419	538	414	556	456	674	457	739	457	739
Зүрх, судасны тогтолцооны өвчин	1525	2262	1584	2224	1518	2085	1509	2140	1509	2140
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	706	3086	675	3264	846	3460	803	3498	803	3498


Хүснэгт.7.8 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, насны бүлгээр, 2019 он

	20 хүртэлх	20-44	45-64	65-аас дээш
Амьсгалын тогтолцооны өвчин	614	232	245	191
Зүрх, судасны тогтолцооны өвчин	101	335	947	693
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	672	543	609	326
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	219	1149	560	326
Мэдрэлийн тогтолцооны өвчин	149	292	279	94

Зураг.7. 56 Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтын хувь, сумдаар, 2019 он



Хөхний эрт илрүүлгийн хүзлэгт хамрагдалт, 2019 оноор




Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалт, 2019 оноор



Зураг.7. 57 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, бэрхшээлийн хэлбэр, 10 000 хүн амд



Зураг.7. 58 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насны бүлгээр, 10 000 хүн амд




БҮЛЭГ VIII. ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ


Зураг.8. 1 Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, өвчлөлийн түвшин /10 000 хүн амд




Зураг.8. 2 Осол гэмтэл гадны шалтгаант нас баралт,10 000 хүн амд, 2015-2019 он




Зураг.8.3 Осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөл 10 000 хүн амд



Зураг.8.4 Осол гэмтлийн өвчлөл, байршлаар, тохиолдлын тоо, 2015-2019 он



Зураг.8. 5 Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, хүйсээр, эзлэх хувиар /2015-2019он/



Хүснэгт.8. 1. Осол гэмтлийн өвчлөл, улирлаар, 2019 он


2019 оны өвчлөл								
	I улирал		II улирал		III улирал		IV улирал	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Зам тээврийн осол/V00-V99/	42	9	53	11	65	32	37	15
Бүх төрлийнуналт/W00-W19/	38	39	49	48	28	25	37	33
Амьгүй механик хүчинд өртөх/W20-W49/	18	7	19	7	29	15	25	15
Амьтай механик хүчинд өртөх/W50-W64/	9	14	26	14	14	12	6	7
Түлэгдэлт /W85-X19/	13	6	9	6	2	10	7	4
Хорт амьтан ургамалд өртөх /X20-X29/	0	0	1					
Байгалийн хүчинд өртөх /X30-X39/	5	6					2	1
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх /X40-X49/	3	1	1		3	1		
Бусад болон тодорхойгүй гадны хүчин зүйлд өртөх /X58-X59/						1		

Хүчирхийлэл /X85- Y09/	14	7	7	7	20	11	20	10
---------------------------	----	---	---	---	----	----	----	----


Хүснэгт.8. 2 Осол гэмтлийн шалтгаант нас баралт, улирлаар, 2019 он

	2019 оны нас баралт							
	I улирал		II улирал		III улирал		IV улирал	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Зам тээврийн осол/V00-V99/	6		3		5	1	2	
Бүх төрлийнуналт/W00-W19/			1				1	
Амьгүй механик хүчинд өртөх/W20-W49/					1			
Усанд унаж живэх/W65-W74/	1		2		2			
Амьсгал боох аюултай бусад осол /W75-W84/								1
Түлэгдэлт /W85-X19/	1				1			
Байгалийн хүчинд өртөх /X30-X39/	3		1	1				3
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх /X40-X49/	3		1	1	4			2
Амиа хорлохыг завдах /X60-X84/	1		5		7			2
Хүчирхийлэл /X85-Y09/					1			
Тодорхойгүй сэдлээр учруулсан гэмтэл /Y10-Y34/	2							

Зураг.8. 6 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны ангиллаар, тохиолдлын тоогоор, 2019 он



Зураг.8.7 Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын шалтгаан, эзлэх хувиар, 2010-2019 он




Хүснэгт.8. 3 Амиа хорлолт, насны бүлгээр, хувиар, 2015-2019 он

	2015	2016	2017	2018	2019
10-14 нас	4.8	6.7	0.0	10.5	0
15-19 нас	23.8	0.0	22.2	15.8	6.7
20-24 нас	14.3	6.7	16.7	5.3	0.0
25-29 нас	4.8	20.0	11.1	0.0	13.3
30-34 нас	14.3	6.7	16.7	15.8	40.0
35-39 нас	14.3	6.7	0.0	21.1	0.0
40-44 нас	9.5	0	5.6	5.3	13.3
45-49 нас	9.5	0	5.6	21.1	13.3
50-54 нас	4.8	40.0	11.1	0.0	13.3
55-59 нас	0.0	13.3	11.1	0.0	0.0
60-аас дээш нас	0.0	0.0	0.0	5.3	0.0


БҮЛЭГ IX. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

Манай Аймгийн хүн амын нас баралт сүүлийн 10 жилийн дунджаар харвал жилд 643 буюу 1000 хүн амд ногдох нас баралтын ерөнхий коэффициент 4.2 байгаа нь улсын дунджаас 1.5 пунктээр бага байна. Хүн амын нас баралт 2019 онд 587 болж, сүүлийн 10 жилийн дундажаас 56 тохиолдлоор, өмнөх оноос 73-аар тус тус буурсан байна. Нас баралтын ерөнхий коэффициент (1000 хүн амд ногдох нас баралт) сүүлийн 10 жилд 2010 онд хамгийн өндөр 6.4 байсан бол хамгийн бага нь 2019 онд 5.1 байна.

Зураг.9.1 Хүн амын нас баралтын түвшин (1000 хүнд ногдох), хүйсээр, Өвөрхангай аймаг, 2010-2019 он




Зураг.9.2 Эрэгтэйчүүдийн нас баралт, насны бүлгээр, 2019 он



2019 оны байдлаар эрэгтэйчүүдийн нас баралтын 34 тохиолдол өсвөр насанд /0-14/ тохиолдож 9 хувийг, 156 тохиолдол нь хөдөлмөрийн насандаа /15-59/ нас барж 43 хувийг, 173 тохиолдол тэтгэврийн насанд /60-аас дээш/ нас барж 48 хувийг тус тус эзэлж байна.

Зураг.9.3 Эрэгтэйчүүдийн нас баралт, насны бүлгээр, 2019 он



2019 оны байдлаар эмэгтэйчүүдийн нас баралтын 19 тохиолдол 0-14 насанд тохиолдож 9 хувийг, 54 тохиолдол нь хөдөлмөрийн насандаа /15-59/ тохиолдож 24 хувийг, 151 тохиолдол 60-аас дээш буюу тэтгэврийн насандаа нас барж 67 хувийг тус тус эзэлж байна.

ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Зүрх судасны тогтолцооны өвчний улмаас улсын хэмжээнд жил бүр 5000-5500 хүн буюу 3 хүний нэг нь нас барж байгаа бол манай аймгийн хувьд сүүлийн 10 жилийн дундажаар жилд 290 хүн тус өвчлөлийн шалтгаанаар нас барж нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

Сүүлийн 10 жилийн дундажаар хүн амын нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 58.6% эрэгтэйчүүд, 41.4% нь эмэгтэйчүүд байна.

Зүрх судасны тогтолцооны өвчнөөс зүрхний ишемит өвчин, тархины цус харвалт, бусад зүрх судасны тогтолцооны өвчин, зүрхний шигдээс дийлэнх хувийг эзэлж байна.


Эдгээр нийтлэг өвчин тус бүрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй их байна. Нас барсан хүмүүсийн насны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү залуу насандаа нас барсан нь эрэгтэйчүүдийн дийлэнх нь 45-с дээш настай, эмэгтэйчүүдийн дийлэнх нь 60-с дээш настай байгаагаас харагдаж байна. 2019 онд зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 23.4, 10 000 эмэгтэй хүн амд 16.8 ногдож байна.

Зураг.9. 4 Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар 10 000 хүн амд ноогдох зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 20.1 байгаа нь өмнөх оноос 5.1 пунктээр, сүүлийн 10 жилийн дунджаас 5.5 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Зураг.9. 5 Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, хүйсээр, 2010-2019 он



2019 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судасны тогтолцооны өвчний 14.6 хувийг зүрхний шигдээс өвчний шалтгаант нас баралт эзэлж


байгаа нь улсын дундажаас 30.1 пунктээр бага байна. 2019 онд зүрхний шигдээсээр нийт 34 хүн нас барсан нь сүүлийн 10 жилийн дундажаас 10 тохиолдлоор буюу 22.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 10 000 хүн амд зүрхний шигдээсын шалтгаант нас баралтыг хүйсээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 3.4 дахин их байна.

Зураг.9. 6 Зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтын түвшин, 10 000 хүнд амд, 2010-2019 он




Зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтыг хүйсээр авч үзвэл 2019 онд 10 000 эрэгтэйд ноогдох түвшин 5.0 болж, 10 жилийн дундажаас 1.1 пунктээр, 10 000 эмэгтэйд ноогдох түвшин 0.9 болж, 10 жилийн дундажаас 0.9 пунктээр буюу 2 дахин тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.9. 7 Зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтын түвшин, Өвөрхангай аймаг, 10 000 хүнд амд, хүйсээр, 2010-2019 он




Сүүлийн 10 жилийн дундажаар зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын 37.9 хувийг тархинд цус харвалтын шалтгаант нас баралт эзэлж байна. 2019 оны байдлаар 10 000 хүн амд ногдох тархинд цус харвалтын шалтгаант нас баралт 4.6 болж улсын дундажтай ижил түвшинд байгаа бол сүүлийн 10 жилийн дундаж 9.7 байгаа нь улсын дундажаас 2.9 пунктээр өндөр үзүүлэлттэй байна.

Зураг.9. 8 Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, 2010- 2019 он



Зураг.9. 9 Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, хүйсээр, 2010- 2019 он



ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Хавдраас шалтгаалсан нас баралт 1990 оноос хойш нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд сүүлийн 10 жилд нас барагчдыг хүйсээр авч үзэхэд 54.2 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж, нас барж байна. 2019 оны байдлаар хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 28.3 хувийг эзэлж улсын дундажаас 1.8 пунктээр их байна.

Сүүлийн 10 жилийн дундажаар нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 10.7, 10 000 эмэгтэй хүн амд 9.0 байна. Нас баралтын зонхилох өвчлөлийн хоёр дахь гол шалтгаан болох хавдраас шалтгаалсан нас баралт 2019 оны байдлаар 55.5% нь эрэгтэй, 44.5.% нь эмэгтэй хүмүүс буюу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.2 дахин их байна.

Хавдрын төрлийн хувьд дийлэнх нь элэг ба элгэн дэх цэсний сувгийн хорт хавдар, ходоодны хорт хавдар болон амьсгуурсны (bronхын) ба уушгины хорт хавдраас болж нас барсан байна.

Зураг.9. 10 Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, 2010-2019 он




Зураг.9. 11 Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2010-2019 он



Элэгний хорт хавдар нь хүн амын нас баралтыг өвчлөлөөр тооцоход эрэглтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын 1-р шалтгаан болсоор байна. Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын 59 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 5.1 ноогдож байга нь өмнөх оноос 0.8 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажаас 0.7 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн дундажаар эрэглтэйчүүд 51.3 хувийг, эмэгтэйчүүд 48.7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг.9. 12 Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, хүйсээр, 2010-2019 он




Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 2010 онд нийт нас баралтын 6.9 хувийг эзэлж байсан бол 2019 онд 45 тохиолдол буюу 7.7 хувийг эзэлж байна. 2019 оны байдлаар 10 000 хүн амд ноогдох нас баралтын түвшин 3.9 байгаа нь улсын дунджаас 0.2-оор их байгаа бол аймгийн сүүлийн 10 жилийн дундажаас 0.4 пунктээр бага үзүүлэлттэй байна.

Зураг.9. 13 Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 оны байдлаар хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 10 000 эрэгтэйд 3.9 байгаа нь өмнөх оноос 0.8 пунктээр, сүүлийн 10 жилийн дундажаас 0.9 пунктээр тус тус буурсан байна.

Зураг.9. 14 Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, хүйсээр, 2010-2019 он




Сүүлийн 10 жилийн хугацаанд хоол боловсруулах өвчний шалтгаанаар нийт 485 тохиолдол бүртгэгдэж жилийн дундаж 48 байна.

Зураг.9. 15 Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 2010-2019 он



2019 оны байдлаар хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралтын 46.7 хувийг элэгний цирроз ба фиброзын шалтгаант нас баралт эзэлж байгаа бол сүүлийн 10 жилийн хугацаанд элэгний циррозын шалтгаант нас баралтын 261 тохиолдож хоол боловсруулах тогтолцооны 53.8 хувийг эзэлж байна. Насны ангиллаар харуулбал, сүүлийн 10 жилийн хугацаанд эрэгтэйчүүдийн нас баралт 54.4 хувийг эзэлж байна.

Зураг.9. 16 Элэгний циррозын шалтгаант нас баралт, Өвөрхангай аймаг, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 34 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 7 тохиолдлоор буюу 20.6 хувиар нэмэгдсэн байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 308 тохиолдол бүртгэгдсэнээс 60.4 хувь нь эрэгтэй, 2019 онд 34 тохиолдол бүртгэгдсэнээс 64.7 хувь нь эрэгтэй байна.

Зураг.9. 17 Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин, улс, аймаг, 10 000 хүн амд




2019 оны байдлаар 10 000 эмэгтэйд ноогдох нас баралтын түвшин 2.1 байгаа нь сүүлийн 10 жилийн дундажтай ижил түвшинд, 10 000 хүн амд ноогдох эрэгтэйчүүдийн нас баралт 3.8 байгаа нь 10 жилийн дундажаас 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг.9. 18 Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин, хүйсээр, 10 000 хүн амд




2019 оны байдлаар уушигны хатгалгаа өвчний шалтгаант нас баралт 10 000 хүн амд 1.2 байгаа нь улсын дундажаас 0.2 пунктээр бага байгаа ба нийт амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 41.2 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилд уушигны хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын 157 тохиолдол бүртгэгдэж амьсгалын тогтолцооны өвчний нас баралтын 51.0 хувийг эхэлж байна.

Зураг.9. 19 Уушгины хатгаа өвчний шалтгаант нас баралт, Өвөрхангай аймаг, 2010-2019 он



Уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын 10 000 эрэгтэйд ноогдох түвшин 2010 онд 2.9 болж эмэгтэйгээс 1.1 пунктээр өндөр үзүүлэлттэй байсан бол 2019 онд ижил түвшинд байна.


Зураг.9. 20 Уушгины хатгаа өвчний шалтгаант нас баралт, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын хэлбэрээр авч үзвэл сүүлийн 10 жилийн хугацаанд осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 847 тохиолдол бүртгэгдснээс 30.3 хувийг зам тээврийн осол эзэлж байна. 2019 онд улсын хэмжээнд 557 хүн зам тээврийн ослоор нас барсан бол манай аймагт 17 тохиолдол бүртгэгдэж улсын дүнгийн 3.1 хувийг эзэлж байна. 2019 оны байдлаар эрэгтэйчүүдийн зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс 16 дахин, 10 жилийн дундажаар 5.4 дахин их байна.

Зураг.9. 21 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он



2019 онд зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 17 тохиолдол бүртгэгдснээс 94.1 хувийг, сүүлийн 10 жилд 257 тохиолдол бүртгэгдснээс 84.4 хувийг тус тус эрэгтэйчүүд эзэлж байна.


Зураг.9. 22 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, хүйсээр, 10 000 хүн амд



АМИА ХОРЛОЛТ

Сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 629 орчим хүн нас барснаас 2.8% орчим хувь нь амиа хорлон нас баржээ. Аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар амиа хорлосон нас баралт 10 000 хүн тутамд 1.25 байсан бол 2019 онд 1.29 хүн болж өссөн байна. Хүйсээр авч үзвэл: 2010-2019 онд нийт 174 амиа хорсон нас барсан хүн амын 89.0 хувь нь эрэгтэйчүүд байна. Амиа хорлогчдын тоо 2019 онд 15 байгаа нь нийт нас баралтын 3.1 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажаас нийт нас баралт 2, эмэгтэйчүүд 4 тохиолдлоор тус тус буурч, эрэгтэйчүүдийн нас баралт 1 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Зураг.9. 23 Амиа хорлолт, улс, аймгаар, 10 000 хүн амд, 2010-2019 он




2019 онд амиа хорлолтын 15 тохиолдол бүртгэгдэж бүгд эрэгтэйчүүд байна.

Зураг.9. 24 Амиа хорлолт, Өвөрхөнгөй аймаг, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он



Зураг.9. 25. Насны бүлэгт тооцсон нас баралтын шалтгаан, 2019 он



Хүснэгт.9. 1 Нас баралтын тэргүүлэх шалтгаан, хүйсээр, 10 000 хүн амд, 2010-2019 он

	2010		2011		2012		2013		2014		2015		2016		2017		2018		2019	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Зүрх судасны тогтолцооны өвчин	31.4	24.6	32.2	23.9	35.1	26.3	33.4	22.0	29.0	19.9	30.7	18.4	33.3	18.2	25.6	17.8	29.2	23.4	23.3	16.7
Хавдар	11.5	7.4	10.4	6.0	7.9	6.7	10.9	6.1	11.0	11.4	11.1	8.7	9.3	9.5	11.5	12.6	10.8	10.8	13.1	10.4
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант нас баралт	12.8	3.2	13.3	2.8	13.8	2.6	12.3	2.2	11.0	2.1	14.3	1.8	13.2	4.4	11.5	2.6	12.5	2.9	10.7	0.5
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	4.1	4.6	5.9	4.1	5.6	3.0	6.2	4.2	2.7	3.4	4.5	4.2	4.4	4.1	4.6	3.1	5.4	4.1	4.7	3.1

Хүснэгт.9. 2 Хорт хавдрын тэргүүлэх шалтгаант нас баралт, тохиолдлын тоогоор, 2010-2019 он


	2010		2011		2012		2013		2014		2015		2016		2017		2018		2019	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн (C22)	36	19	27	15	19	15	27	15	27	28	30	24	18	29	32	31	17	33	24	35
Ходоодны өмөн (C16)	7	4	2	8	9	6	8	5	11	6	6	4	9	3	6	7	14	8	20	2
Улаан хоолойн өмөн (C15)	5	5	2	2	7	6	3	1	4	3	6	7	4	6	5	7	9	4	6	7
Амьсгуурс ба уушгины өмөн (C34)	6	0	12	1	4	0	9	3	11	4	8	0	6	1	9	7	9	0	8	1
Нойр булчирхайн өмөн (C25)	0	0	0	1	0	2	2	2	1	2	2	1	2	0	3	5	1	1	3	2
Хөхний өмөн (C50)	0	0	0	1	0	1	0	1	0	1	0	2	0	1	0	1	0	1	0	2
Умайн хүзүүний өмөн (C53)	0	6	0	6	0	1	0	1	0	9	0	4	0	1	0	3	0	3	0	3
Түрүү булчирхайн өмөн (C61)	1	0	1	0	0	0	0	0	0	0	1	0	2	0	2	0	0	0	4	0

Хүснэгт.9. 3 Хорт хавдрын шалтгаант тэргүүлэх нас баралт, хүйсээр, 10 000 хүн амд

	2010		2011		2012		2013		2014		2015		2016		2017		2018		2019	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн (C22)	6.5	3.4	4.9	2.7	3.4	2.6	4.9	2.7	4.9	5.0	5.4	4.2	3.2	5.1	5.6	3.4	5.0	5.7	4.1	6.0
Ходоодны өмөн (C16)	1.3	0.7	0.4	1.4	1.6	1.1	1.5	0.9	2.0	1.1	1.1	0.7	1.6	0.5	1.2	1.4	2.4	1.4	3.4	0.3
Улаан хоолойн өмөн (C15)	0.9	0.4	0.4	0.4	1.3	1.1	0.5	0.2	0.7	0.5	1.1	1.2	0.7	1.1	0.9	1.2	1.6	0.7	1.0	1.2


БҮЛЭГ Х.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Зураг8.1. 1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, сая, төгрөгөөр /2010-2019 он/




Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2019 он

Зураг8.1. 2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцан төлсөн иргэдийн тоо, Өвөрхангай, 2010-2019 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2019 он

Зураг8.1. 3. Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтын судалгаа, Өвөрхангай, 2010-2019 он



Бүлэг XI. Үндэсний хөтөлбөрүүд

1. МУИХ, МУЗГ-ЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

№	Нэр	Шийдвэрийн огноо, дугаар
1	“Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөр	2017-09-27 МУЗГ-ын 289 дүгээр тогтоол
2	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2013-12-14 МУЗГ-ын 416 дугаар тогтоол
3	“Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь хөтөлбөр	2009-09-30 МУЗГ-ын 303 дүгээр тогтоол
4	“Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2016.01.04 МУЗГ-ын 4 дүгээр тогтоол
5	“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр	2017-01-11 МУЗГ-ын 11 дугаар тогтоол
6	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2017-03-07 МУЗГ-ын 78 дугаар тогтоол
7	“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр	2017-04-12 МУЗГ-ын 112 дугаар тогтоол
8	“Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр	2015-11-16 МУЗГ-ын 447 дүгээр тогтоол
9	“Хог хаягдлын менежментийг сайжруулах” үндэсний хөтөлбөр	2014-9-18 МУЗГ-ын 298 дугаар тогтоол
10	“Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2017-08-09 МУЗГ-ын 225 дугаар тогтоол
11	“Авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөр	2016-11-03 МУИХ-ын 51 дүгээр тогтоол
12	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөр	2017-03-07 МУЗГ-ын 77 дугаар тогтоол
13	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр	2017-09-20 МУЗГ-ын 270 дугаар тогтоол
14	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр	2017-11-29 МУЗГ-ын 321 дугаар тогтоол

15	Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр	2018-05-30	МУЗГ-ын 163 дугаар тогтоол
16	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үнэдсний хөтөлбөр	2019-05-12	МУЗГ-ын 193 дугаар тогтоол
17	Эрүүл шүд - Эрүүл хүүхэд	2018-08-15	МУЗГ-ын 255 дугаар тогтоол
18	Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр	2019-05-01	МУЗГ-ын 171 дугаар тогтоол

2. МУЗГ-ЫН ТОГТООЛ, ЭМС-ЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

№	Нэр	Шийдвэрийн огноо, дугаар
1	“Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги” төлөвлөгөө батлах тухай	2014-10-10 ЭМСС-ын 335 тушаал
2	“Давсны хэрэглээг бууруулах” стратеги	2015-08-31 МУЗГ-ын 353 тогтоол

3. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ИТХ-ЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН ХӨТӨЛБӨР

№	Хөтөлбөрийн нэр	Шийдвэрийн огноо, дугаар
1	“Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр	2012-03-27 Аймгийн Засаг даргын а/113 дугаар захирамж
2	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих аймгийн хөтөлбөр	2019-08-29 Аймгийн Засаг даргын 55 дугаар захирамж
3	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр	2017-04-28 Аймгийн Засаг даргын а/199 дүгээр захирамж
4	“Хүүхдэд ээлтэй-Аймаг” хөтөлбөр	2017-07-03 Аймгийн ИТХ-ын 56 дугаар тогтоол

5	“Адил боломж” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах дэд хөтөлбөр	2017-04-28	Аймгийн ИТХ-ын 39 дүгээр тогтоол
6	“Төрийн албан хаагчдын сургалт-хөгжил” аймгийн хөтөлбөр	2017-11-09	Аймгийн Засаг даргын а/525 дугаар захирамж